# МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2016 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, 2017-2018 ОНЫ ХАНДЛАГА

*Иргэдэд зориулав*









## *Арга зүйн хялбаршуулсан танилцуулга*

*Улаанбаатар хот 2015 он*

Ж.Батсайхан

# МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2016 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, 2017-2018 ОНЫ ХАНДЛАГА

АРГА ЗҮЙН ХЯЛБАРШУУЛСАН
ТАНИЛЦУУЛГА

Улаанбаатар хот
2015 он

# Өмнөх үг



Улсын Их Хурлын 2015 оны хаврын чуулганаар Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэлэлцэн баталлаа.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл нь Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, Засгийн газрын 2012–2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангах, инфляцийг бууруулах, төсвийн тогтвортой, тэнцвэртэй байдлыг хангах бодлогыг хөрөнгө оруулалт, өрийн удирдлагын оновчтой бодлогоор дэмжих, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ажилгүйдлийн түвшинг бууруулах, бодит салбарын өсөлтийг дэмжиж, салбар тус бүрийн үйл ажиллагааг эрчимжүүлэх хүрээнд бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхэд төвлөрч байна.

2016 оны хөгжлийн үндсэн чиглэл нь Макро, эдийн засгийн бодлого; Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлого; Бүс нутаг, хөдөөгийн хөгжил, байгаль орчны бодлого; Хүний хөгжил, нийгмийг хөгжүүлэх бодлого; Засаглал, эрх зүйн шинэчлэл, гадаад бодлого, батлан хамгаалах салбарын бодлого гэсэн нийт 5 бүлэг, 20 гаруй зорилт, 130 гаруй бодлогын арга хэмжээтэй байхаар боловсрогдлоо.

Макро эдийн засгийн бодлогын хүрээнд эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийг 5 хувь, инфляцийн түвшинг нэг оронтой тоонд, ажилгүйдлийн түвшинг 7.0 хувь, нэгдсэн төсвийн алдагдлыг 4 хувьд тус тус байлгахаар төлөвлөв.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг түгээн сурталчлах, түүнийг судлан танилцах үйл ажиллагаанд тус дэм болох зорилгоор энэхүү хялбаршуулсан арга зүйн танилцуулгыг товхимол хэлбэрээр иргэн Танд хүргүүлж байгаадаа баяртай байна.

Ард иргэд, олон нийтийн зүгээс төрийн эдийн засаг, нийгмийн бодлогыг хэр зэрэг ойлгож дэмжинэ, төдийчинээ үр дүнтэй хэрэгждэг. Тийм ч учраас төрийн бодлого, шийдвэрийг олон түмэнд илүү ил тод, нээлттэй байлгахад Улсын Их Хурлаас онцгой ач холбогдол өгдөг билээ.

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**
**Ж.БАТСУУРЬ**

# ТОВХИМЛООС ЮУ МЭДЭЖ БОЛОХ, ТҮҮНИЙГ ХЭРХЭН АШИГЛАХ ТУХАЙД

Товхимолтой бүхэлд нь танилцсанаар улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийг төлөвлөхөд хэрэглэгддэг гол гол үзүүлэлт, тэдгээрийн тодорхойлолтууд, тооцооны зарим аргачлал, 2016 онд улс орноо хөгжүүлэх талаар тавьж байгаа зорилт, хэрэгжүүлэх томоохон арга хэмжээний талаар товч ойлголт авах болно.

Товхимлын хэсэг тус бүрийн агуулгын задаргааг нарийвчлан дугаарласан (1.2.1. гэх мэт) нь сонирхсон зүйлтэйгээ хэсэгчилэн танилцах боломжийг олгоно.

Эдийн засаг, нийгмийн асуудлын гол гол үзүүлэлтүүд, тэдгээрийн нэр томъёоны тодорхойлолт, тооцооны аргачлалын талаар тойм ойлголт өгөх үүднээс тусгайлан хайрцагласан “тодруулга”-ыг хийж өгөв.

**I хэсгээс** эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, 2017-2018 оны хандлагын талаар “зорилт-арга хэмжээ” гэсэн дарааллаар,

**II хэсгээс** УИХ-ын тогтоол, шаардлагатай зарим албан мэдээлэлтэй танилцах боломжтой.

Товхимолд тусгагдсан тоо баримт нь 2015 оны 6 дугаар сарын 11-ний 52 дугаар тогтоол, Засгийн газраас УИХ-д өргөн мэдүүлсэн тогтоолын төсөл, түүний танилцуулга, хавсралт тооцоо, тоо баримтаас эх сурвалжтай болно.

Боловсруулж, хэвлэлд бэлтгэсэн
багийн гишүүд

# АГУУЛГА

**I ХЭСЭГ. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2016 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, 2017-2018 ОНЫ ХАНДЛАГА 5-44**

**1.1. 2016 оны үндсэн чиглэлийн агуулга, зорилтууд 6**
**1.2. Макро эдийн засгийн 2016 оны төлөв 8**
1.2.1. Эдийн засгийн бодит өсөлт 9
1.2.2. Хэрэглээний үнийн түвшин /инфляци/ 12
1.2.3. Валютын ханшны төлөв 15
1.2.4. Гадаад худалдааны төлөв 17
1.2.5. Төлбөрийн тэнцлийн төлөв байдал 20
1.2.6. Улсын төсвийн орлого, зарлагын төлөв 24
**1.3. Бодит салбарын хөгжил 2016 онд 26**
1.3.1. Уул уурхайн салбарын хөгжил 27
1.3.2. Эрчим хүчний хөгжил 28
1.3.3. Аж үйлдвэрийн салбарын хөгжил 29
1.3.4. Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрийн салбарын хөгжил 30
1.3.5. Зам тээвэр, барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуйн салбарын хөгжил 31
**1.4. Хүний хөгжил 2016 онд 33**
1.4.1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт 35
1.4.2. Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал 37
1.4.3. Эрүүл мэнд 39
**1.5. Бүс нутаг, байгаль орчин, аялал жуулчлалын салбарын төлөв 2016 онд 41**
**1.6. Гадаад бодлого, батлан хамгаалах салбар 2016 онд 43**
**1.7. Засаглал, эрх зүйн шинэчлэлийн төлөв 2016 онд 44**

**II ХЭСЭГ. АЛБАН МЭДЭЭЛЭЛ, ХАВСРАЛТУУД 46-73**
**2.1. Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай УИХ-ын тогтоол 46**
**2.2. Хавсралтууд 71**

# I ХЭСЭГ



# МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2016 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ, 2017-2018 ОНЫ ХАНДЛАГА

# 1.1. ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2016 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН АГУУЛГА, ЗОРИЛТУУД

**АГУУЛГА**

**2016**

- ✓ Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогын хүрээнд Шинэчлэлийн Засгийн газрын 2012–2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх, эдийн засгийн өсөлтийг хангах, инфляцийг бууруулах, төсвийн тогтвортой, тэнцвэртэй байдлыг хангах бодлогыг хөрөнгө оруулалт, өрийн удирдлагын оновчтой бодлогоор дэмжих, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ажилгүйдлийн түвшинг бууруулах, бодит салбар тус бүрийн үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр бодлогын арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- ✓ Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр хөдөө аж ахуй, фермерийн аж ахуй, үйлдвэрлэл, эрчим хүч, дэд бүтэц, уул уурхай, аялал жуулчлал, үйлчилгээний салбаруудыг дэмжих чиглэлээр тодорхой бодлого хэрэгжүүлэн ажиллах бөгөөд эдгээр салбаруудын өсөлтийн үр дүнгээр ДНБ–ий өсөлтийг хангаж ажиллах бодлого баримтална.
- ✓ Нийгмийн суурь үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.

## ЗОРИЛТ 2016

- Эдийн засгийн хүндрэлийг даван туулж, макро эдийн засгийг тогтворжуулах бодлого баримтална.
- Санхүүгийн эх үүсвэрүүдийг бүрэн дайчилж, үр ашгийг дээшлүүлэх замаар хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- Гадаад худалдааны таатай орчныг бүрдүүлж, экспортыг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.
- Мал аж ахуй, газар тариалангийн салбарын хөгжлийг эрчимжүүлэх бодлого хэрэгжүүлнэ.
- Экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжинэ.
- Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.
- Бодит салбарын өсөлтийг хангах эрчим хүчний бодлогыг хэрэгжүүлж, шинэ эх үүсвэрүүдийн барилгын ажлыг эхлүүлнэ.
- Монгол Улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжихэд чиглэсэн тээврийн салбарыг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлнэ.
- Геологи, эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэх замаар ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
- Бодит салбарын хөгжлийг дэмжсэн шинжлэх ухаан, технологийн хөгжлийн бодлого баримтална.
- Хүн амын нутагшилт, суурьшил, бүс нутгийн зохистой тогтолцоонд тулгуурлан хот, суурин хөгжүүлж, газар ашиглалтыг сайжруулна.
- Хөдөөгийн хөгжлийг дэмжиж, хүн амын амьдрах орчныг сайжруулна.
- Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлнэ.
- Гамшгаас хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, мэргэжлийн байгууллагын бие бүрэлдэхүүн, аврагчийн бие бялдрын тэсвэр хатуужил, сэтгэл зүйн бэлтгэлийг төлөвшүүлнэ.
- Хүүхэд, сурагч, оюутан нэг бүрийг хөгжүүлж, багш нарын ур чадварыг дээшлүүлнэ.
- Эх орондоо эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээг чанарын өндөр түвшинд хийх боломжийг бүрдүүлнэ.
- Соёл, биеийн тамир, спортыг тогтвортой хөгжүүлж, биеийн тамирыг хүний өдөр тутмын хэрэглээ болгох бодлого баримтална.
- Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх ажлыг эрчимжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- Нийгмийн даатгал, нийгмийн хамгааллын салбарт хийх шинэчлэлийн бодлогыг үргэлжлүүлнэ.
- Хууль тогтоомж, эрх зүйн шинэчлэлийн бодлогыг дэмжих ажлыг үргэлжлүүлнэ.
- Энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт, идэвхтэй гадаад бодлого явуулна.
- Батлан хамгаалахын чадавхыг нэмэгдүүлж, улс орны бүтээн байгуулалтад оролцох боломжийг дээшлүүлнэ.

# 1.2. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН 2016 ОНЫ ТӨЛӨВ

**ЗОРИЛТ**

**2016**

- ✓ Эдийн засгийн хүндрэлийг даван туулж, макро эдийн засгийг тогтворжуулах бодлого баримтална.
- ✓ Санхүүгийн эх үүсвэрүүдийг бүрэн дайчилж, үр ашгийг дээшлүүлэх замаар хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

***Тодруулга1***

- ***ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО:***
  Аливаа улс орны төр, засгаас эдийн засгийн талаар заавал шийдвэрлэж байх дараахь зорилтуудыг эдийн засгийн бодлого гэнэ. Үүнд:

| | |
|---|---|
| Эдийн засгийн эрх чөлөөг хангах | Аж ахуйн үйл ажиллагаанд оролцож буй үйлдвэрлэгч, хэрэглэгч бүх субъектийн эрх мэдэл, өмчийн эрх чөлөөг хангах, сонголт хийх боломж |
| Ажлаар бүрэн хангах | Ажлын чадвартай ажиллахыг хүсч буй бүх хүмүүс ажилтай байх бололцоог хангах замаар ажилгүйдлийн түвшинг зохистой хэмжээнд барих |
| Эдийн засгийн өсөлтийг хангах | Хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэх |
| Үнийн тогтвортой байдлыг хангах | Инфляцийн эсрэг үйл ажиллагаа явуулах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах |
| Орлогыг шударга хувиарлах | Цөөн бүлгийн тансаг хэрэглээг улам нэмэгдүүлэхгүйгээр, бусад бүлгүүдийн амьдралыг ядуурахад оруулахгүй байхаар орлогыг хуваарилах |
| Хүн амд эдийн засгийн халамж үзүүлэх | Хөдөлмөрийн чадваргүй ажил хийх боломжгүй хүмүүсийн амьдралын баталгааг хангах |
| Гадаад худалдааны тэнцлийг хангах | Гадаад худалдаа, санхүүгийн гадаад харилцаанд оновчтой тэнцвэр бүрдүүлэх |
| Хүрээлэн буй орчныг хамгаалах | Эдийн засгийн хөгжил ба хүрээлэн буй орчны зохицолдоог хангах |

# 1.2.1 ЭДИЙН ЗАСГИЙН БОДИТ ӨСӨЛТ

**2016**

- **Эдийн засгийн бодит өсөлтийг 5.0 хувьд байлгана.**
- **Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний* хэмжээг 4400.0 ам.долларт хүргэнэ.**

**Эдийн засгийн өсөлт, салбараар**

| | 2013 | 2014* | 2015** | 2016** | 2017** | 2018** |
|---|---|---|---|---|---|---|
| ДНБ, оны үнээр тэрбум төгрөг | 19,118.0. | 21,844.2 | 24,027.1 | 27,020.5 | 30,427.5 | 34,097.5 |
| Өөрчлөлт | 14.6 | 14.3 | 10.0 | 12.5 | 12.6 | 12.1 |
| Эдийн засгийн бодит өсөлт | 11.6 | 7.8 | 5.3 | 5.0 | 4.4 | 6.8 |
| Хөдөө аж ахуй | 19.3 | 14.4 | 10.8 | 10.4 | 9.1 | 3.1 |
| Үйлдвэрлэл | 15.3 | 16.1 | 8.7 | 0.2 | 1.2 | 8.6 |
| Үйлчилгээ | 6,8 | 4.8 | 3.8 | 7.0 | 3.8 | 6.6 |
| Уул уурхай | 19,4 | 24.2 | 11.3 | –6.4 | –5.2 | 13.4 |
| Уул урхайн бүс | 9,8 | 3.6 | 3.4 | 8.8 | 7.1 | 5.1 |

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Сангийн яам
* –урьдчилсан гүйцэтгэл
** –төсөөлөл

тодруулга 2–ыг үз

**2016 онд
Эдийн засгийн өсөлтөд нөлөөлөх
хүчин зүйлүүд**

- ✓ Уул уурхайн салбар 2016 онд Оюу толгойн зэсийн баяжмал, алтны агуулга буурч байгаатай холбоотойгоор 6 орчим хувиар буурах эрсдэлтэй байна. Харин нүүрсний үнэ 2016 оноос эхлэн бага зэрэг нэмэгдэх хандлагатай байгаа ба төрийн эзэмшлийн Таван толгойн ордод стратегийн хөрөнгө оруулагч сонгон шалгаруулж, гэрээ байгуулснаар Нүүрсний олборлолт 2016 онд 14 орчим хувиар өсөж, 30 орчим сая тоннд хүрэх бололцоотой.
- ✓ Хөдөө аж ахуйн салбар 10,4 хувиар өсөхөөр байна. Газар тариалангийн салбарт 2016 онд 560 орчим мянган тонн улаанбуудай, 260 мянга орчим тонн төмс, 170 орчим мянган тонн хүнсний ногоо хураан авахаар төлөвлөж байна. Байгаль цаг уурын байдал ирэх жилүүдэд олон жилийн дундаж түвшинд байвал мал сүргийн тоо толгой 2016 онд 60 гаруй саяд хүрэхээр байна. Ингэснээр мал аж ахуйн салбар 2016 он 9 орчим хувиар өсөх төлөвтэй байна.
- ✓ Хөгжлийн банкны санхүүжилтийн дэмжлэгтэйгээр тус бүр 1 сая тонны хүчин чадалтай цементийн үйлдвэрийн 2 төсөл 2016–2017 онд ашиглалтад орж, үйл ажиллагаагаа эхлүүлснээр боловсруулах аж үйлдвэрийн салбарын өсөлтийг 11–12 хувиар өсгөхөөр байна.
- ✓ Монгол Улсын эдийн засгийн өсөлт саарч байгаа хэдий ч Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, Таван толгойн ордыг өргөтгөх хөрөнгө оруулалт 2015–2018 онуудад манай улсад орж ирснээр барилга болон худалдааны салбарын өсөлтийг дэмжихээр байна.
- ✓ Оны үнээр илэрхийлсэн ДБН 2016 онд 13 орчим хувиар өсөж, 27.0 их наяд төгрөгт хүрэхээр байна.

## Эдийн засгийн бодит өсөлт, 2014–2015 оны урьдчилсан гүйцэтгэлээр

- 2014 оны урьдчилсан гүйцэтгэлээр эдийн засаг 7.8 хувиар өсч, ДНБ–ий хэмжээ нэрлэсэн үнээр 21,844.2 тэрбум төгрөгт хүрсэн байна.
- 2014 онд нэг хүнд ногдох ДНБ–ий хэмжээ 4072.3 ам.доллар болов.
- Эдийн засгийн бодит өсөлтийг 2015 онд 5.3 хувь байхаар урьдчилан төсөөлж байна.
- Нэг хүнд ногдох ДНБ–ий хэмжээ 2015 онд 4013.4 ам.долларт хүрэх урьдчилсан тооцоо гарч байна.

### *Тодруулга 2*

- **ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ** гэдэг нь дараа жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсвийг зохиоход Засгийн газраас баримтлах үзүүлэлтүүдийн хязгаар, үндсэн тэнцвэрийг тодорхойлж, Улсын Их Хурлаас зөвшөөрсөн баримт бичиг, эсхүл баталсан хууль юм.
- **ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ.** Эдийн засгийн өсөлтийг нэлээд өргөн хэрэглэгдэж байгаа дараах хоёр тодорхойлолтоор хэмждэг:

  ✓ Ашиглаж байгаа үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн тоо хэмжээг нэмэгдүүлсний буюу техник технологийг боловсронгуй болгосны үр дүнд үндэсний хийт бүтээгдэхүүн /ҮНБ/–ий хэмжээнд гарах бодит өөрчлөлтөөр

  ✓ Нэг хүн амд ногдох бодит орлогын хэмжээ нэмэгдэх буюу ҮНБ–ний бодит хэмжээ өсөх үйл явцаар

$$\text{Эдийн засгийн өсөлтийн хурдац} = \frac{\text{(тухайн оны ҮНБ)} * 100\%}{\text{суурь оны ҮНБ}}$$

- Улс орны дотооддоо тухайн жилд үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүнийг **“ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН”** гэдэг бөгөөд тухайн орны үйлдвэрлэх хүчний нөөцөөр нэг жилд үйлдвэрлэж бий болгосон материал баялгийн хэмжээг зах зээлийн өртгөөр илэрхийлдэг. Нийт бүтээгдэхүүнийг хүн амд хуваавал нэг хүнд ногдох хэмжээ гарна. Үүгээр улс орны хөгжлийн болон амьдралын түвшинг тооцоолдог. Нийт бүтээгдэхүүний хэмжээ, түүний өсөлт нь улс орны хөгжлийн шийдвэрлэгч хүчин зүйл юм.
- ДНБ дээр тухайн улсын иргэдийн гадаад дахь хөрөнгө оруулалтаас олох орлогыг нэмбэл үндэсний нийт бүтээгдэхүүн /ҮНБ/ гарна.
- Үндэсний нийт бүтээгдэхүүнээс капиталын элэгдэлийн шимтгэлийг хасвал **ҮНДЭСНИЙ ЦЭВЭР БҮТЭЭГДЭХҮҮН** гарна.

***Тодруулга 2-ийн үргэлжлэл***

- Дотоодын нийт бүтээгдэхүүнээс шимтгэлийг хасвал **ДОТООДЫН ЦЭВЭР БҮТЭЭГДЭХҮҮН** гарна.
- Үндэсний нийт бүтээгдэхүүнээс шимтгэл ба шууд биш татваруудыг хасвал цэвэр орлогуудын нийлбэр буюу **ҮНДЭСНИЙ ОРЛОГО** гарна.
- Үндэсний орлогоос пүүсүүдийн хувьцаа эзэмшигчиддээ өгөлгүй хөрөнгө оруулалт хийсэн ашиг болон татварыг хасч дээр нь тэтгэвэр, тэтгэмж зэрэг эдийн засагчдын хэллэгээр "шилжүүлэх төлбөр"-ийг нэмбэл хүмүүсийн гар дээр бэлэн очих "хэрэглээнд зарцуулах" буюу **"БЭЛЭН ОРЛОГО"** гарна.

## 1.2.2. Хэрэглээний үнийн түвшин (Инфляци)

**2016**

- **Инфляцийг онилсон мөнгөний бодлого хэрэгжүүлж, инфляцийн зорилтот түвшинг /жилийн дундаж хэмжээ/ нэг оронтой тоонд байлгана.**

***Инфляцийн түвшин***




*тодруулга 3-ыг үз

**2016 онд**
**Инфляцид нөлөөлөх**
**хүчин зүйлс:**

- ✓ –Хөгжлийн банкнаас дэд бүтэц, үйлдвэрлэлийн томоохон бүтээн байгуулалтын ажлыг дэмжихээр төлөвлөөд байна. Тухайлбал, импортын бараа бүтээгдэхүүнийг орлох дотоодын үйлдвэрлэлийг дэмжих, барилгын материалыг дотоодод үйлдвэрлэх зэрэг төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.
- ✓ 2015 онд батлагдсан эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөрийн хүрээнд дунд хугацаанд концессын гэрээгээр дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэх, экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлуулах үйлдвэрлэлийн үйл ажиллагааг дэмжин ажиллах болсонтой уялдан дунд хугацаанд инфляцийн түвшин нам тогтвортой түвшинд буюу нэг оронтой тоонд байхаар байна.

**Хэрэглээний үнийн индекс /инфляци/, 2014–2015 оны урьдчилсан гүйцэтгэлээр**

- ➢ Хэрэглээний үнийн индексээр илэрхийлэгдсэн инфляцийн түвшин 2014 оны эцсээр улсын хэмжээнд 11.0 хувьтай гарлаа.
- ➢ 2015 онд нийлүүлэлтийн шинж чанартай инфляцийн түвшин буурах хандлагатай байгаа бөгөөд мөн хөрш орнуудын инфляцийн түвшин бага байхаар хүлээгдэж, мөн Япон улстай хийсэн гэрээ хэлэлцээрээр автомашин, эм бэлдмэл зэрэг 5700 нэрийн бараа, бүтээгдэхүүнийг гаалийн татвараас чөлөөлөх шийдвэр гарсан зэргээс үүдэн манай улсын инфляцийн түвшин 2015 онд нэг оронтой тоонд байх төлөвтэй байна.

## Тодруулга 3

- **ҮНИЙН ЕРӨНХИЙ ТҮВШИН** (Инфляци). – Энэ нь үнийн индексийн тусламжтай хэмжиж байгаа өргөн хэрэглээний бүлэг барааны буюу хэрэглээний сагс болгон тооцсон барааны үнийн дундаж түвшинг тодорхойлдог. Үнийн индекс нь тодорхой хугацааны доторх үнийн дундаж түвшингийн өөрчлөлтийг илэрхийллэх ба дараах томъёогоор тооцно.

$$\text{Тухайн жилийн үнийн индекс} = \frac{\text{Тухайн оны үнэ} * 100\%}{\text{Суурь оны үнэ}}$$

- ✓ Хэрэглээний сагс гэдэг бол амьдралынхаа хэвийн үйл ажиллагааг хангаж байгаа статистикийн дундаж амьжиргаатай гэр бүлийн хэрэгцээг хангахад зайлшгүй шаардагдах бараа үйлчилгээний цуглуулга юм..

- ✓ Манай оронд хэрэглээний үнийн индексийн сагсыг 1991 оны 9 дүгээр сараас Олон улсын Валютын сангийн аргачлалаар тооцож эхэлсэн бөгөөд 2001 оноос эхлэн хэрэглээний сагсанд 280 гаруй нэрийн бараа, үйлчилгээг багтааж хэрэглээний үнийн индексийг тооцож байна

## 1.2.3. Валютын ханшны төлөв

**2016**

- Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцэж, уян хатан тогтох зарчмыг үргэлжлүүлэн баримтална.

***Тодруулга 4***

- **Валютын ханшийг тодорхойлдог хүчин зүйлүүд:**
  - ✓ Эдийн засгийн гол үйл явдлууд /арга хэмжээнүүд/
  - ✓ Бүтээмжийн өөрчлөлт
  - ✓ Мөнгө санхүүгийн талаарх төрийн бодлого
  - ✓ Үнэ, зээлийн хүү
  - ✓ Улс төр, сэтгэл зүйн хүчин зүйлүүд
  - ✓ Хүлээлт
  - ✓ Гадаад валютын эрэлт нийлүүлэлт

- **Валютын зах зээлийг зохицуулах талаар Засгийн газраас авч байгаа арга хэмжээ нь өөрийн үндэсний валютын ханшид девальваци болон ревальваци хийх чиглэлээр валютын зах зээлийг өдөөж байдаг.**
  - ❖ ***Девальваци нь*** өөрийн орны валютын солилцооны ханшийг бууруулахад /сулруулах/ чиглэгдсэн Засгийн газрын үйлдлийг хэлдэг. Девальвацийн үед бусад орнууд импортоор худалдан авсан бараандаа бага валют төлөх учраас тухайн экспортлогч орны бараа үйлчилгээний үнэ олон улсын зах зээл дээр хямдарч буй илэрхийлнэ. Харин хилийн чанадаас тухайн орны худалдан авсан бараа үйлчилгээний үнэ нэмэгдэж, улмаар импорт хумигдахад нөлөөлж, дотоодын эрэлт буудаг.
  - ❖ ***Ревальваци нь*** өөрийн орны валютын солилцооны ханшийг өсгөхөд (чангаруулах) чиглэгдсэн Засгийн газрын үйлдлийг хэлдэг.
  - ❖ ***Валютын интервенци нь*** гадаад орны валютыг худалдах, худалдан авах замаар үндэсний валютын ханшид нөлөөлөх үйлдэл.

## Тодруулга 5

- **Голланд өвчин:**

Эдийн засагт шинээр хөрөнгө оруулалт орж ирэх нь бусад салбарын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, эдийн засгийн зарим салбар уналтад орох тохиолдол байдаг. 1959 онд Нидерландын хойд тэнгист газрын тос илэрсний улмаас газрын тосны үйлдвэрлэл нэмэгдэж улмаар тосны экспорт өсчээ. Гэвч дотоод валютын ханш чангарсны улмаас бусад салбарын экспорт буурч, газрын тосноос бусад салбарт ажилгүйдэл нэмэгдэх байдлаар эдийн засагт сөргөөр нөлөөлсөн байна. Ханшийн чангаралтын нөлөөгөөр боловсруулах салбарын худалдаалагддаг төрлийн бүтээгдэхүүний өрсөлдөх чадвар буурч, үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлдөг энэхүү байдлыг голланд өвчин гэж нэрлэдэг бөгөөд газрын тосны олборлолтоос өмнө Нидерландын экспортын гол бүтээгдэхүүн байсан Алтанзул цэцгийн экспорт эрс буурч, эдийн засгийн өрөөсгөл бүтэц бий болж байжээ. Тодруулбал, эдийн засгийн нэг салбарын үйл ажиллагаа бусад салбарын үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлөхийг ГОЛЛАНД ӨВЧИН гэдэг байна.

- **Баялгийн хараал:**

Ангол, Нигер, Судан, Конго зэрэг Африк тивийн ихэнхи орнууд газрын тос, очир алмаз гэх мэт үнэт эрдэнээр баялаг боловч байгалийн баялаггүй зүүн өмнөд Азийн орнууд болох Япон, Өмнөд Солонгос, Тайвань, Сингапур зэрэг оронтой харьцуулахад амьдралын чанар доогуур, нэг хүнд ногдох орлого маш бага байна. Баялагтай боловч хөгжил буурай байгаа эдгээр орнуудыг **"баялагийн хараал"** тусчээ гэж дүгнэдэг. Байгалийн баялаг арвинтай орнуудын нэг хүнд ногдох орлогын өсөлт нь баялагийг ашиглаагүй үеийн нэг хүнд ногдох орлогын өсөлтөөс доогуур байх үзэгдлийг БАЯЛАГИЙН ХАРААЛ гэж тодорхойлох бөгөөд улс орнууд баялагийн хараалд өртдөг олон шалтгаан байдаг байна. Тухайлбал, тухайн орны эдийн засаг цөөн тооны түүхий эд, баялагийн дэлхийн зах зээл дээрх үнийн хэлбэлзлээс хэт хамааралтай, эмзэг бүтэцтэй байх, Засгийн газар нөөцийг үр ашиггүй удирдах, улс төрийн тогтворгүй байдал, авлигал зэрэг нь улс орныг баялагийн хараал тусахад хүргэдэг байна.

## 1.2.4. Гадаад худалдааны төлөв

**2016**

- ✓ Гадаад худалдааны бараа эргэлт 2016 онд 10.0 тэрбум ам.доллар, үүнээс экспорт 5.1 тэрбум ам.доллар, импорт 4.9 тэрбум ам.доллар болж гадаад худалдааны тэнцэл ашигтай гарахаар байна.
- ✓ Экспортын хэмжээ 2016 онд 2015 оноос 0.9 хувиар буурахаар байна.
- ✓ 2016 онд Оюу толгойн баяжмал дахь алтны агууламж буурах, эрдэс бүтээгдэхүүний дэлхийн зах зээл дээрх үнэ төдийлөн өсөхгүй байх зэргийн улмаас уул уурхайн бүтээгдэхүүний экспорт 3 хувиар буурахаар байна.
- ✓ Мал аж ахуйн түүхий эдийн экспорт буурахаар байна.
- ✓ Уул уурхайн бүс бүтээгдэхүүн оёдол, нэхмэл, махны экспорт нэмэгдэж, 764,4 сая ам.доллар болох төлөвтэй байна.
- ✓ Импортын хэмжээ 2016 онд өмнөх оноос 13.8 хувиар өсөхөөр байна.
- ✓ Оюу толгойн төслийн 2 дахь үе шат, Таван толгойн орд, Цагаан суваргын баяжуулах үйлдвэр зэрэг бүтээн байгуулалтын ажил эхлэхтэй холбоотойгоор импорт өснө.

## ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ
## 2016

- ✓ Тарифын болон тарифын бус саад тотгорыг бууруулж, хөрш болон гуравдагч орны зах зээлд хөнгөлөлттэй нөхцөлөөр бараа, бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг бүрдүүлнэ.
- ✓ Дэлхийн худалдааны байгууллагатай тохирсон хэмжээнд багтаан импортын зарим бараанд ногдуулах гаалийн татварыг нэмэгдүүлж, дотоодын үйлдвэрлэлийг дэмжинэ.
- ✓ “Замын-Үүд” эдийн засгийн чөлөөт бүс, “Алтанбулаг” болон “Цагааннуур” худалдааны чөлөөт бүсүүдийн дэд бүтцийг барьж байгуулна
- ✓ Гадаад худалдааг хөнгөвчлөх “Цахим нэг цонх” хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ..

### Гадаад худалдаа, 2014-2015 оны урьдчилсан гүйцэтгэлээр



- ➢ Монгол Улсын гадаад худалдааны бараа эргэлт 2014 онд 11.0 тэрбум ам.доллар болж 2013 оныхоос 3.6 хувиар өсөв.
- ➢ Монгол Улсын нийт экспорт 2014 онд 2013 оноос 35.3 хувиар өсөж, 5.8 тэрбум ам.доллар болов.
- ➢ Импорт 2014 онд 17.6 хувиар буурч, 5.2 тэрбум ам.доллар болж, гадаад худалдааны тэнцэл 0.5 тэрбум ам.долларын ашигтай гарав.
- ➢ Экспорт 2015 онд 2014 оноос 10.6 хувиар буурч, 5.1 тэрбум ам.доллар, импорт 16.7 хувиар буурч, 4.3 тэрбум ам.доллар болох төлөвтэй байна.

## Тодруулга 6

- *Ямар ч улс орны хувьд гадаад худалдааны гол асуудал нь экспорт нь импортоосоо ямагт түрүүлж байх явдал юм. Энэхүү үйл явцыг улсын хэмжээнд харуулдаг нэгдсэн үзүүлэлт бол гадаад худалдааны* ***бараа эргэлт*** *юм.*

- *Гадаад худалдааны бараа эргэлт гэж экспорт дээр импортыг нэмсэн нийлбэрийг хэлдэг.*

***Гадаад худалдааны эргэлт = экспорт+импорт***

- *Экспорт, импортын нийлбэрээр гадаад худалдааны эргэлтийг тодорхойлдог бол экспорт, импортын зөрүүгээр гадаад худалдааны тэнцлийг тодорхойлдог.*

- *Хэрэв +(нэмэх) тэмдэгтэй гарвал гадаад худалдааны тэнцэл ашигтай, улс орны хөгжил дэвшил дээгүүр байгааг илэрхийлнэ.*

*Улс орны эрх ашиг, аюулгүй байдлыг хангах үүднээс улс орон бүхэн импортоосоо давсан экспорттой байх нь хамгийн гол зорилт байдаг хэдий ч эдийн засгийн чадавхи, улс орны хөгжлийн түвшингөөс хамаараад улс орон бүхэн ингэж чаддаггүй.*
*Гадаад худалдааны алдагдалыг арилгах арга зам нь үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, үүний дотор олон улсын зах зээлийн шаардлага хангасан чанартай, хүний орчин үеийн хэрэглээнд илүү нийцэж тохирсон үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд анхаарах явдал юм.*

## 1.2.5. Төлбөрийн тэнцлийн төлөв

**ЗОРИЛТ**

**2016**

- Гадаад худалдаа 2016 онд ашигтай байхтай уялдан төлбөрийн тэнцлийг эерэг буюу алдагдалгүй болгох бодлого баримтална.

**Төлбөрийн тэнцэлд нөлөөлөх хүчин зүйлс**

**2016**

- ✓ Хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээж, хөрөнгө оруулалтыг татах, хөрөнгө оруулалтын орчныг сурталчлах цогц арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.
- ✓ Орон нутгийн хөгжлийн сангийн үр өгөөж, ашиглалтыг сайжруулна.
- ✓ Засгийн газрын өрийн баталгааны сангийн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, үйл ажиллагааг эхлүүлнэ.
- ✓ Оюутолгойн далд уурхайн хөрөнгө оруулалтын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ.
- ✓ Таван толгойн төслийг үргэлжлүүлнэ.
- ✓ Үндэсний давхар даатгалын корпораци байгуулна.
- ✓ Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг жигдрүүлж дэмжинэ.
- ✓ Тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлэх замаар үндэсний үйлдвэрлэлийг дэмжинэ.
- ✓ Банкны салбарт эрсдэл хуримтлагдах зээлийн тасалдал үүсэх, системийн шинжтэй тогтворгүй байдал бий болохоос сэргийлэх арга хэмжээ авна.
- ✓ Нийгмийн даатгалын зарим төрлийг хувийн амьдралын даатгалд шилжүүлэх замаар урт хугацааны болон хувийн тэтгэврийн даатгалын зах зээлийг хөгжүүлнэ.

## Төлбөрийн тэнцэл, 2014 оны урьдчилсан гүйцэтгэлээр

- 2014 оны гүйцэтгэлээр төлбөрийн тэнцэл 471.1 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдал нь өмнөх оноос 3.9 дахин буурав.

*Төлбөрийн тэнцэл /сая.ам доллар/*

| | 2012 | 2013 | 2014 |
|---|---|---|---|
| Төлбөрийн тэнцэл | 1705 | –1883.3 | –471.1 |
| Урсгал данс | –3362.2 | –3155.6 | –981.7 |
| Хөрөнгө ба санхүүгийн данс | 4929.5 | 1471.6 | 771.5 |

Эх сурвалж: Монголбанкны гадаад секторын статистик мэдээлэл

Төлбөрийн тэнцлийг дансуудаар авч үзвэл, урсгал данс 981.7 сая ам.долларын алдагдалтай гарч 2012 оны мөн үеэс алдагдал нь 3.2 дахин буурсан, хөрөнгө ба санхүүгийн данс 771.5 сая ам.долларын ашигтай гарч өмнөх оны мөн үеэс 1.9 дахин буурсан байна.

## Тодруулга 7

**ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ** бол улс орны гадаад эдийн засгийн тухайн үеийн байдлыг илэрхийлдэг чухал ойлголт юм.
Төлбөрийн тэнцэл нь тухайн жилийн хугацаанд аль нэг орны хувь хүмүүс, пүүс компани, Засгийн газрын байгууллагуудаас бусад орнуудын мөн тийм хэмжэний субъектүүдтэй хийсэн гэрээ, хэлцлүүдийн нэгтгэсэн тэнцэл бөгөөд дараахь 3 хэсгээс бүрддэг.

***I. Урсгал дансны тооцоо (а+б+1.5.+1.6.)***

1.1.Барааны экспорт
1.2. Барааны импорт

а.Гадаад худалдааны тэнцлийн үлдэгдэл(+,-) ашигтай эсвэл алдагдалтай

1.3.Үйлчилгэний орлого
1.4.Үйлчилгээний зарлага

б. Худалдаа үйлчилгээний тэнцлийн үлдэгдэл (+,-)

1.5.Хөрөнгө оруулалтаас орох цэвэр орлого (–)
- –гадагш шилжүүлсэн ногдол ашиг
- –хамтарсан үйлдвэрийн хийсэн дахин хөрөнгө оруулалтын хэмжээ

1.6.Урсгал шилжүүлгүүд /цэвэр/ [+,–]
- –Засгийн газрын шилжүүлгүүд
- –Хувийн гуйвуулгууд

***II. Капиталын хөдөлгөөн буюу Санхүүгийн ба хөрөнгийн дансны тооцоо***

2.1.Капиталын экспорт
- 2.1.1.Урт ба дунд хугацааны хөрөнгө оруулалт
  - –шууд хөрөнгө оруулалт
  - –санхүүгийн хөрөнгө оруулалт
  - –ашигласан зээл

2.2. Капиталын импорт
- 2.2.1.Зээлийн үндсэн өрийн төлбөр
- 2.2.2. Богино хугацааны зээл
- 2.2.3 Бусад төлбөр

Санхүүгийн ба хөрөнгийн тэнцлийн үлдэгдэл (+,-)

**Нийт төлбөрийн тэнцэл =Урсгал дансны тэнцэл (I)+санхүүгийн болон хөрөнгийн дансны тэнцэл (II)**

***III Гадаад валютын албан нөөц***

Төлбөрийн тэнцлийн тэнцвэргүй байдлыг улс өөрийн төв банкны мэдэлд байгаа гадаад валютын албан нөөцийг ашиглах замаар даван туулж болдог.

## Тодруулга 7-ийн үргэлжлэл

- **Гадаад валютын цэвэр албан нөөцийг** гадаад актив / валютын харилцах, хадгаламж, кассын үлдэгдэл, мөнгөжсөн алт, гадаад орны Засгийн газрын үнэт цаас/, богино хугацаатай пассив /богино хугацаатай гадаад өр, гадаадын хөрөнгө/ -ын зөрүүгээр тооцдог.

| | |
|---|---|
| + | ***Гадаад актив*** (валютын харилцах+хадгаламж+кассын үлдэгдэл+мөнгөжүүлсэн алт+гадаадын Засгийн газрын үнэт цаас) |
| – | ***Богино хугацаатай пассив*** (гадаад өр+гадны хөрөнгө) |
| = | ***Гадаад валютын цэвэр албан нөөц*** |

❖ Мөнгөжсөн алт нь олборлосон алтыг хайлуулан цэвэршүүлж гадагш худалдахад бэлэн болгосныг хэлдэг бөгөөд гадаад валют гэж тооцогддог.

- **Гадаад валютын улсын цэвэр нөөцийг** арилжааны бүх банкуудын гадаад актив, богино хугацаатай гадаад пассивын зөрүүгээр тооцдог.

- **Нийт мөнгө /М2/ нь** банкнаас гадуур байгаа бэлэн мөнгө, банкинд байгаа харилцах дансдын үлдэгдэл /М1/ дээр төгрөгийн хадгаламж, гадаад валютын харилцах, хадгаламжийг нэмсэн нийлбэр юм.

## 1.2.6.Улсын төсвийн төлөв байдал

**2016**

Дотоодын нийт бүтээгдэхүүнд нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлогын эзлэх хэмжээг 24.6 хувь, (6.642,0 тэрбум төг)

Дотоодын нийт бүтээгдэхүүнд нэгдсэн төсвийн нийт зарлагын эзлэх хэмжээг 28,6 хувь, (7,722.8 тэрбум төг)

Дотоодын нийт бүтээгдэхүүнд нэгдсэн төсвийн алдагдалын эзлэх хэмжээг 4,0 хувь (–1,080.8)

Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлт 5,0 хувь

**ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**

**2016**

- ✓ Татварын шинэчлэлийг гүнзгийрүүлж, энгийн ойлгомжтой, олон улсын жишигтнийцүүлэх замаар бизнес эрхлэгч, бага орлшготой иргэдийг дэмжих.
- ✓ Өрийн удирдлагын дунд хугацааны стратегийг хэрэгжүүлж, дунд хугацаанд учирч болзошгүй төлбөрийн эрсдэлийг бууруулах.

## Тодруулга 8

- **УРСГАЛ ТЭНЦЭЛ** нь төсвийн урсгал орлого, урсгал зарлагын зөрүүгээр илэрхийлэгддэг бөгөөд төлөвлөсөн урсгал хэрэгцээгээ /зардлаа/ хасаад цаана нь өр зээл болон хуримтлал /хөрөнгө оруулалт/–д зориулагдан үлдэж буй хөрөнгийн хэмжээг харуулдаг үзүүлэлт бөгөөд тухайн улс орны төсвийн дотоод эх үүсвэрийн чадавхийг илтгэдэг.

- **ТӨСВИЙН НИЙТ ТЭНЦЭЛ** нь төсвийн нийт орлого, нийт зарлагын зөрүүгээр тус тус илэрхийлэгддэг бөгөөд төлөвлөсөн нийт хэрэглээг /нийт зардлыг/ хангахад дутагдаж буй хөрөнгийн хэмжээг харуулдаг үзүүлэлт бөгөөд тухайн улс орны Засгийн газарт нэмэлт дотоод, гадаад эх үүсвэр /зээл/ шаардагдаж байгааг илтгэн үзүүлдэг.

*Улсын төсвийн нийт тэнцэл зохих түвшинд алдагдлатай байх тохиолдол нь хэвийн үзэгдэл байдаг бөгөөд энэ алдагдалыг:*
*–гадаад /цэвэр/*
*–дотоод /цэвэр/ эх үүсвэрүүдээр санхүүжүүлэн тэнцвэржүүлдэг.*

- ✓ *Гадаад /цэвэр/ эх үүсвэр нь төслийн болон санхүүгийн эх үүсвэр байдаг.*

- ✓ *Дотоодын /цэвэр/ эх үүсвэр нь өмч хувьчлалын орлого, банкны болон банкны бус байгууллагаас авах зээл байдаг.*

- ✓ *Цэвэр гэдэг утга нь авах өгөх хоёрын зөрүү буюу авахаас нь өгөхийг хасаад гарсан цэвэр үлдэгдэлийг хэлнэ.*

# 1.3. БОДИТ САЛБАРЫН ХӨГЖИЛ 2016 ОНД

- Мал аж ахуй, газар тариалангийн салбарын хөгжлийг эрчимүүлэх бодлого хэрэгжүүлнэ.
  - ХАА-н салбар 10.4 хувиар өснө.
  - 560 орчим мян.тонн улаан буудай, 430 мянга орчим тонн төмс, хүнсний ногоо хураан авна.
  - Цаг агаар таатай байх нөхцөлд малын тоо 60 гаруй саяд хүрэхээр байна.
- Экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжинэ.
  - Боловсруулах аж үйлдвэрийн салбар 11-12 хувиар өснө.
  - Цементийн 2 үйлдвэр ашиглалтад орно.
- Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.
- Бодит салбарын өсөлтийг хангах эрчим хүчний бодлогыг хэрэгжүүлж, шинэ эх үүсвэрүүдийн барилгын ажлыг эхлүүлнэ.
- Монгол Улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжихэд чиглэсэн тээврийн салбарыг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлнэ.
- Геологи, эрдэс бялгийн салбарыг хөгжүүлэх замаар ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.
  - Нүүрсний үнэ бага зэрэг нэмэгдэх хандлагатай байгаа ба
  - Таван толгой ордод стратегийн хөрөнгө оруулагч шалгаруулан, гэрээ байгуулснаар нүүрс олборлолт 30 орчим сая тоннд хүрэх бололцоотой.
  - Уул уурхайн үйлдвэрлэл 6.4 хувиар буурна.
- Бодит салбарын хөгжлийг дэмжсэн шинжлэх ухаан, технологийн хөгжлийн бодлого баримтална.
- Уул уурхайн бус үйлдвэрлэл 8.8 хувиар өснө.
- Үйлчилгээний салбар 7.0 хувиар өснө.
- Нийгмийн суурь үйлчилгээ /боловсрол, эрүүл мэнд г.м/-ний чанар хүртээмж дээшилнэ.

## 1.3.1. Уул уурхайн салбарын хөгжил

**ЗОРИЛТ**

**2016**

- Геологи, эрдэс бялгийн салбарыг хөгжүүлэх замаар ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ .

**ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**

**2016**

- ✓ Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 2014 оны 7 дугаар сарын 01–ний өдөр УИХ–аар батлагдаж, "ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгохыг хориглох тухай" хуулийг хүчингүй болгосноор ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг эхлүүлж хайгуулын ажилд зарцуулах хувийн хөрөнгө оруулалт нэмэгдэж, эрдэс баялгийн салбарын хөгжил эрчимжих нөхцөл бий болж байна.
- ✓ Уул уурхайн салбарт ашигт малтмалыг хаягдал, бохирдол багатай, хүрээлэн буй орчин, хүний амьдрах орчинд сөрөг нөлөө багатайгаар үйл ажиллагаа явуулах төслийг дэмжихээс гадна экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг дэмжиж ажиллана.
- ✓ Оюу толгойн далд буурхайн бүтээн байгуулалт, Таван толгой төслийн бүтээн байгуулалтыг ажлыг эрчимжүүлнэ.
- ✓ Улаанбаатар хотын Рашаант дахь 100000м3 багтаамж бүхий шатахууны агуулахын барилга угсралтын ажлыг концессын гэрээгээр барьж ашиглалтад оруулан газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангана.
- ✓ Нөөц нь тогтоогдож үйл ажиллагаа явуулахад бэлэн болсон уурхайг ашиглалтад оруулж бүс нутгийн дэд бүтцийн хөгжлийг сайжруулна.
- ✓ Газрын тос боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах.
- ✓ Зэс хайлуулах үйлдвэрийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх.
- ✓ Нүүрсийг шингэрүүлэх, хийжүүлэх, хуурай аргаар боловсруулах үйл ажиллагааг бодлогоор дэмжих.
- ✓ Нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлвийг судлах зорилгоор 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх.
- ✓ Ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлэх.
- ✓ Ашигт малтмалын төрөл, олборлох, боловсруулах технологийн онцлогийг тусгасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх Европын Холбооны стандартыг нутагшуулж, мөрдүүлэх.

## 1.3.2. Эрчим хүчний хөгжил

**ЗОРИЛТ**

**2016**

- Бодит салбарын өсөлтийг хангах эрчим хүчний бодлогыг хэрэгжүүлж, шинэ эх үүсвэрүүдийн барилгын ажлыг эхлүүлнэ.

**ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**

**2016**

- ✓ Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татах таатай нөхцөлийг бүрдүүлэх, бүс нутгийг Эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангах зорилтын хүрээнд “Дорнодын ДЦС-ыг 100 МВт-аар нэмэгдүүлэх, Сайншандад 52 МВт салхин станцыг барих ажлыг эхлүүлэх, “ДЦС-5”, Тавантолгой цахилгаан станц” болон “Багануурын цахилгаан станц”-ын барилга угсралтын ажлыг эхлүүлэх, Эгийн голын 315 МВт-ын хүчин чадалтай УЦС-ын гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, барилга угсралтын ажлын бэлтгэлийг хангуулах, зураг төсвийг боловсруулах болно.
- ✓ Баруун бүсийн нүүрсний уурхайг түшиглэн 60МВт-ын цахилгаан станцыг барих сонгон шалгаруулалтыг явуулах, Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын УЦС барих, аймгийн төвүүд, суурин газрын дулаан хангамжийг найдваржуулах ажлыг дуусгах, Чойр-Сайншанд-Замын-Үүдийн 2 хэлхээт 220 кВ-ын 230 км ЦДАШ, дэд станцыг барих, Улаанбаатар-Мандалговийн өндөр хүчдэлийн 236 км ЦДАШ, дэд станц, Эрдэнэтийн ДЦС-ын хүчин чадлыг 30 МВт-аар нэмэгдүүлэх, Багануурын уурхайн болон Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг өргөтгөж, шинэчлэх төслийн хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэж, өргөтгөлийн ажлыг эхлүүлэх, тус уурхайг түшиглэн цахилгаан станц байгуулж, эрчим хүч экспортлох чиглэлээр холбогдох талтай хэлэлцээ хийх, цахилгаан хангамжид холбогдоогүй хэрэглэгчдийг цахилгаан хангамжаар хангах ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.
- ✓ Түлш, эрчим хүчний үнэ тарифыг үе шаттайгаар чөлөөлж, арилжааны операторын үйл ажиллагааг нэвтрүүлнэ.

## 1.3.3. Аж үйлдвэрийн салбарын хөгжил

**ЗОРИЛТ**

**2016**

- Экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжинэ.
- Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана

**ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**

**2016**

- ✓ Уул уурхайн салбарын бүтээгдэхүүнийг боловсруулалт хийхгүйгээр экспортлох бус, нэмүү өртөг шингэсэн, хагас боловсруулсан болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж экспортлох, хүнд аж үйлдвэрийн салбарыг нэгдсэн бодлого, төлөвлөлттэй буюу аж үйлдвэрийн паркийн зохион байгуулалттайгаар хөгжүүлэх зорилт тавин ажиллаж байна. Энэ хүрээнд нүүрснээс шингэн түлш, хий үйлдвэрлэх үйлдвэр, металлургийн коксын үйлдвэр, зэсийн баяжмал хайлуулах, цэвэршүүлэх үйлдвэр барих байршлыг тогтоох судалгаа хийж, зураг төслийг боловсруулна.
- ✓ Газрын тос боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ, зураг төслийг боловсруулж зэс хайлуулах үйлдвэрийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэнэ.
- ✓ Нүүрсийг шингэрүүлэх, хийжүүлэх, хуурай аргаар боловсруулах үйл ажиллагааг бодлогоор дэмжинэ.
- ✓ Оёмол, нэхмэл, сүлжмэл бүтээгдэхүүн, ноос, ноолуур боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх.
- ✓ Арьс ширийг дотооддоо гүн боловсруулан эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хөрш болон гуравдагч зах зээлд экспортолж зах зээлээ өргөжүүлнэ.
- ✓ Арьс ширийг дотооддоо гүн боловсруулах болон түүгээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үндэсний үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгоно.
- ✓ Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв, бизнес инкубаторыг байгуулах ажлыг орон нутагт үргэлжлүүлж, үйл ажиллагааг өргөжүүлнэ. Сумын хөгжлийн сангийн эх үүсвэр, жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангийн эх үүсвэрийг гадаад, дотоодын нөөц боломжоотой уялдуулж нэмэгдүүлнэ. Зээлийн батлан даалтын сангийн журмуудад өөрчлөлт оруулах замаар зээлийн батлан заалтад хамрагдах иргэд, аж ахуйн тоог нэмэгдүүлж, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид батлан даалтын үйлчилгээнд хамрагдах нөхцөлийг бүрдүүлнэ. Яармаг үзэсгэлэн худалдаанд батлан даалтын дэмжлэг авсан зээлдэгч-дийн бүтээгдэхүүнийг сурталчилж үйл ажиллагааг нь дэмжинэ.
- ✓ Уул уурхайн бус экспортыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг боловсруулна.
- ✓ 2017-2018 онуудад бизнес эрхлэгчдэд шаардлагатай бизнес дэмжих төв, ахуйн үйлчилгээний цогцолбор төвүүд баригдаж, үйл ажиллагаа нь тогтворжсон байна. Мөн хөнгөлөлттэй зээлийн хэрэгцээ шаардлагын 50 орчим хувийг хангах боломжоотой болж, импортыг орлох болон экспортод гаргах бараа, бүтээгдэхүүний нэр төрөл нэмэгдэж, дотоодын нийт бүтээгдэхүүнд жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний хувийн жин нэмэгдэнэ гэж төсөөлж байна.

## 1.3.4. Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрийн салбарын хөгжил

**ЗОРИЛТ**

**2016**

- Мал аж ахуй, газар тариалангийн салбарын хөгжлийг эрчимжүүлэх бодлого хэрэгжүүлнэ.

**ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**

**2016**

- ✓ Хүнс, хөдөө аж ахуйг Монгол Улсын газар зүйн байршил, эко систем, дотоодын болон олон улсын зах зээл, дэд бүтэц, техник, технологийн хөгжлийн чиг хандлага, салбар хоорондын уялдаа холбоо зэрэг олон талт хүчин зүйлд тулгуурлаж, салбарын тогтвортой хөгжлийг хадгалан, үе шаттайгаар хөгжүүлнэ.
- ✓ Мал аж ахуйн салбарыг уламжлалт мал аж ахуйн хэв шинжийг хадгалан хөгжүүлэхийн зэрэгцээ, газар тариалан хөгжсөн бүс нутаг буюу төвлөрсөн хот суурин дагасан эдийн засгийн өндөр ашиг шимтэй эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжиж, хөгжүүлнэ.
- ✓ Үржлийн цөм сүргийн малын тоог нэмэгдүүлнэ.
- ✓ Төв суурин газрын ойролцоо мах, сүүний чиглэлийн хонь, үхрийн болон гахай, шувуны фермерийн аж ахуй байгуулж, дотоодын хэрэгцээг хангах, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.
- ✓ Монгол малын генийн санг хамгаалах, малын нөхөн үржилд биотехнологийн ололтыг нэвтрүүлэх ажлын цар хүрээг нэмэгдүүлнэ.
- ✓ Улсын тусгай хэрэгцээнд авах отрын бэлчээрийн талбайн ашиглалтыг сайжруулах, аймаг дундын болон сум дундын отрын бүсийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлнэ.
- ✓ Малын гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж, мал сүргийг эрүүлжүүлнэ.
- ✓ Газар тариалангийн салбарыг дэвшилтэт техник, технологид тулгуурлан байгаль цаг уурын нөхцөлөөс үл хамаарах, нэгж талбайгаас авах ургацын хэмжээг нэмэгдүүлэх замаар хүн амыг таримал ургамлын гаралтай бүтээгдэхүүнээр бүрэн хангаж, экспортын чиг баримжаатайгаар газар тариалангийн салбарыг хөгжүүлнэ.
- ✓ Газар тариалангийн техник, тоног төхөөрөмжийг бага хүүтэй, урт хугацаатай зээлээр худалдан авах нөхцөлийг бүрдүүлнэ.
- ✓ Хүнс, хүнсний үйлдвэрийн салбарт хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн эрүүл, аюулгүй хүнсний бүтээгдэхүүнээр хангаж, хүнсний үйлдвэрлэлийн салбарыг хэвийн, тасралтгүй үйл ажиллагаа явуулах нөхцөлөөр хангаг хөгжүүлнэ. Хүнс, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэхдээ 2 үе шаттайгаар тус бүр 5 жилийн хугацаатай, 2015–2025 онд хэрэгжүүлнэ.
- ✓ Хоногт 2–5 тонн сүү хөргөх хүчин чадалтай хөргөлтийн төвүүдийг байгуулна.

## 1.3.5. Зам тээвэр, барилга хот байгуулалт, нийтийн аж ахуйн салбарын хөгжил

**ЗОРИЛТ**

**2016**

- Монгол Улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжихэд чиглэсэн тээврийн салбарыг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлнэ.
- Хүн амын нутагшилт, суурьшил, бүс нутгийн зохистой тогтолцоонд тулгуурлан хот, суурин хөгжүүлж, газар ашиглалтыг сайжруулна.

**ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**

**2016**

- ✓ Монгол Улсын тээврийн сүлжээг нэгтгэх бодлогын хүрээнд тээврийн салбарын эрх зүйн орчинг шинэчлэх, Тээврийн үйл ажиллагааны хосолсон нэгдмэл системийг бүрдүүлэх, зам, тээврийн үйлчилгээний төлбөр, тооцоонд цахим карт нэвтрүүлэх зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөж байна. Мөн Улаанбаатар хотын нийтийн тээвэрт тээврийн шинэ төрөл тусгай замын автобусны болон хөнгөн галт тэрэгний үйлчилгээг нэвтрүүлэх, шалган нэвтрүүлэх болон улс, хот хооронд, хотын доторх ачаа тээврийн хөдөлгөөн, ложистикийн дэд бүтцийг бий болгох чиглэлээр ажиллана.
- ✓ Ховдоос Сархайрханы гүүр хүртэлх засмал зам барих асуудлыг судалж шийдвэрлэнэ.
- ✓ Азийн авто замын сүлжээнд холбогдсон АН-4 чиглэлийн авто замын сүлжээг барьж, ашиглалтад оруулна.
- ✓ Аймгийн төвүүдийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбох ажлыг үргэлжлүүлнэ. /Ховд, Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан/.
- ✓ Улсын чанартай авто замын сүлжээний ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах хүрээнд 12.700 км замд засвар арчилгаа хийнэ.
- ✓ Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын 1, 2 дугаар үе шатны төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг үргэлжлүүлнэ.
- ✓ Эрдэнэт-Овоотын 3 дугаар үе шатны төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг эхлүүлнэ.
- ✓ Мандал-Багахангай чиглэлийн Богдхан төмөр замын суурь бүтэц барих төслийг эхлүүлнэ.
- ✓ Даланзадгад, Ховдын нисэх буудлыг олон улсын нөөц нисэх буудал болгон өргөжүүлнэ.
- ✓ Өмнөговь, Дорноговь, Сүхбаатар, Дорнод зэрэг аймгийн дэд бүтэц хөгжиж, дэд бүтцийг дагасан хот, суурин газар бий болох, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх боломж бүрдэн ажлын байр шинээр нэмэгдэж, хүн амын амьжиргааны түвшин дээшилж, амьдрах орчин, нөхцөл сайжирснаар

Үргэлжлэл

төв рүү чиглэсэн хүн амын нүүдэл саарна. Мөн далайд гарцгүй манай улсын гадаад худалдаа, хамтын ажиллагаа өргөжиж, уул уурхайн бүтээгдэхүүнийг ОХУ-д болон гуравдагч орнуудад ОХУ-ын Алс Дорнодын боомтыг ашиглан экспортлох боломж бүрдэж, зүүн болон говийн бүсүүд төмөр замаар холбогдож, хот, суурин газрууд бий болно.

- ✓ Хот байгуулалтын бодлогыг хүн амын уламжлалт нүүдлийн болон эрчимжиж буй суурин соёл иргэншлийн зохистой харьцаанд нийцсэн төрийн цогц бодлого болгох зорилгоор "Хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл боловсруулах", "Аж үйлдвэрийн болон экологийн тэргүүлэх хөгжлийн бүсүүдийг тогтоож, хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах", "Хот байгуулалтын кадастрын мэдээллийн нэгдсэн сан байгуулах", "Бүх аймгийн төв болон 15000-аас дээш хүн амтай суурин газрыг улсын зэрэглэлтэй хот болгох" зорилтуудыг хэрэгжүүлнэ.
- ✓ "Хот байгуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, шинээр "Хот, тосгоны ногоон байгууламжийн тухай" "Авто зогсоолын тухай", "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн бүсчлэлийн" тухай хуулийн төслүүдийг үе шаттайгаар боловсруулж, УИХ-д өргөн барих, "Хотыг дахин хөгжүүлэх тухай" хуулийг дагалдан мөрдөгдөх дүрэм, журмыг боловсруулан мөрдүүлнэ.
- ✓ Газрын кадастрын мэдээллийн систем, газрын бирж байгуулах, геологи, хүрээлэн буй орчны суурь судалгаанд үндэслэсэн газар ашиглалтын төлөвлөгөөг боловсронгуй болгох, олон улсын жишигт хүрсэн газрын төлөв байдал, чанарыг тодорхойлох, үнэлгээ өгөх, өөрчлөлтийг улсын хэмжээнд хянан дүгнэх үүрэг бүхий мониторингийн сүлжээ байгуулах зэрэг зорилт, арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- ✓ Түрээсийн оронс ууц хөтөлбөр батлагдаж, хөтөлбөрийн хүрээнд аймаг бүрт 60-аас доошгүй айлын түрээсийн орон сууц, нийслэлд 800 айлын түрээсийн орон сууц баригдаж ашиглалтад орно.
- ✓ "Аймаг бүрт 1000 айлын орон сууц" төсөл хэрэгжүүлэх, ажлын хүрээнд аймгуудын ус хангамж, ариутгах татуургыг өргөтгөн шинэчилж, хүчин чадлыг нэмэгдүүлснээр 1000 айлын орон сууц, сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг нийгмийн дэд бүтцийн барилга байгууламж барих боломж бүрдэх болно.
- ✓ "Сумын төвийн шинэчлэл хөтөлбөрийн хүрээнд сумын төвүүдэд ус хангамж, ариутгах татуургын барилга байгууламж, шугам сүлжээний зураг төсөл боловсруулах, барилга угсралтын ажлыг эхлүүлэх зорилтын хүрээнд 50 сумын төвийн инженерийн дэд бүтцийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр концессын гэрээгээр гүйцэтгүүлэхээр бэлтгэж байна.

# 1.4. ХҮНИЙ ХӨГЖИЛ 2016 ОНД

- *Монгол Улсын хүн ам 2015 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр 3,0 саяд хүрлээ.*

- *Монгол Улсын хүн ам 2015-2018 онд жилд дунджаар 2.2 хувиар өсөхөөр байна.*

- *Монгол Улсын хүний хөгжлийн индекс 1995 оноос хойш тогтвортой өсч ирсэн. 2013 оны байдлаар Монгол Улсын хүний хөгжлийн ерөнхий индекс 0.728 байна. Монгол Улсын Хүний хөгжлийн индекс нь хүний хөгжил дунд түвшний бүлэг орнуудын дунджаас дээгүүр байна. Хөгжиж буй бусад орнуудтай харьцуулахад Монгол Улсын хүн амын бичиг үсгийн мэдлэг, боловсролын түвшин харьцангуй өндөр байна. Хүн амын боловсролын түвшний индекс 0.940 байна. Харин Монгол хүний дундаж наслалт 68.7 жил байгаа нь дэлхийн дунджаас (69.3 жил) доогуур байна.*

- *Монгол Улс 2015 он гэхэд хүний хөгжлийн индексийг 0.830-д хүргэх Мянганы хөгжлийн зорилт дэвшүүлсэн болно. Сүүлийн 2 жилд Монгол Улсын нийгмийн хөгжилд гарсан ахиц дэвшлийн үр дүнд 2016 он гэхэд хүний хөгжил өндөртэй улсуудын бүлэгт багтах бүрэн боломж байна.*

**Тодруулга 9**

## Хүний хөгжлийн индекс /ХХИ/

- Хүний хөгжлийн индексийг иргэдийнх нь дундаж наслалт, боловсрол (насанд хүрсэн хүн амын бичиг үсэгт тайлагдсан байдал, бүх нийтийн боловсролд хамрагдсан байдал), бодит орлого (нэг хүнд оногдох ДНБ-ий хэмжээ, худалдан авах чадвараар хэмжигдэх амьдралын түвшин) гэсэн үндсэн гурван хэмжүүрийг ашиглан тооцож байна. Эдгээр хэмжүүрүүд нь тус бүртээ өөрийн индекстэй бөгөөд тухайн улсын дундаж наслалт нь 85, нэг хүнд ногдох ДНБ жилд 40 мянган ам.доллар, насанд хүрсэн бүх хүн уншиж, бичиж чаддаг, хүүхэд багачууд нь бүх шатны сургуульд 100 хувь хамрагддаг бол "1" гэсэн оноо авах юм. Хүний хөгжлийн индексийг гаргаснаар хувь хүний амьдралын түвшинг дээшлүүлж, нийгмийн бүх салбарт хөгжиж, боловсрох боломжийг бий болгох арга хэмжээ авахад ашигладаг байна.

  ✓ ***Боловсролын индексийг*** насанд хүргэгчдийн бичиг үсэгт тайлагдсан байдал, бага дунд дээд боловсролд хамрагдсанаар тэгээс нэг хүртэлх оноогоор хэмжиж байгаа бөгөөд 0.9-өөс дээш оноо авах нь боловсролтой, хөгжилтэй улсыг илэрхийлдэг байна. Хүн амын боловролын түвшний индексээр хамгийн өндөр нь Австрали Улс (0.993), Норвеги Улс (0.989) тэргүүлж байна.

  ✓ ***Дундаж наслалт*** өндөр хөгжилтэй орнууд эдийн засгийн хувьд хүчирхэг бөгөөд иргэд нь өрсөлдөх чадвар хамгийн өндөр байдагийг үздэг байна. Дэлхийд дундаж наслалтаар хамгийн өндөр үзүүлэлттэй нь Япон Улс 0.973 (82.7 жил) байна.

  ✓ ***Дотоодын нийт бүтээгдэхүүнийг*** Дэлхийн банкны системээр эдийн засгийн бүх орлогыг тооцох болон хэрэглээ, үйлчилгээ, экспорт зэргээр бүх зардлаар нь тооцдог байна. Дэлхийн банкны тооцоогоор нэг иргэнд 11.9 мянган ам.доллараас дээш мөнгөн дүн ногдож байвал өндөр орлоготой, 3.8 мянгаас 11.9 мянган ам.доллар бол дундаас дээгүүр орлоготой, 976-аас 3.8 мянган ам.доллар бол дунд зэргийн, 975 ам доллараас доош орлоготой бол буурай оронд тооцогддог байна. Энэ үзүүлэлтээр АНУ тэргүүлж, хамгийн өндөр нь байгаа бөгөөд Япон удаалсан байна.

## 1.4.1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт

**ЗОРИЛТ**

**2016**

- Бодит салбарын хөгжлийг дэмжсэн шинжлэх ухаан, технологийн хөгжлийн бодлого баримтална.
- Хүүхэд, сурагч, оюутан нэг бүрийг хөгжүүлж, багш нарын ур чадварыг дээшлүүлнэ.
- Соёл, биеийн тамир, спортыг тогтвортой хөгжүүлж, биеийн тамирыг хүний өдөр тутмын хэрэглээ болгох бодлого баримтална.

**ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**

**2016**

- ✓ "Зөв монгол хүүхэд хөтөлбөр"–т тусгагдсан сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай сургууль, цэцэрлэгийн барилгын өргөтгөл, засварын ажлыг төсвийн тодорхой эх үүсвэр, концесс болон гадаад улс орон, олон улсын байгууллагуудын санхүүжилтээр үргэлжлүүлнэ.
- ✓ Авьяас, ном, багшийн хөгжил, сургалтын орчин, хэрэглэгдэхүүний хүртээмжийг сайжруулах дэд хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ. Бага, суурь, бүрэн дунд боловсролын шинэчилсэн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чухал шаардлагатай лаборатори, тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүн, сурах бичгээр хангана. Тусгай хэрэгцээт боловсролын сургалтын орчинг сайжруулж, сургалтын хөтөлбөр, сурах бичгийг боловсронгуй болгоно. Боловсролын удирдлага, мэдээллийн үндэсний системийг хөгжүүлнэ.
- ✓ Хүүхэд бүрийг хөгжүүлэхэд чиглэсэн багшлах арга зүйд тулгамдаж буй асуудлыг судлан илрүүлж, шийдвэрлэх арга замыг сонгон ажлын байран дээрээ тасралтгүй хөгжих таатай нөхцөл бүрдүүлэх, хүүхдийг хөгжүүлдэг багш төлөвшүүлэх, тэргүүн туршлагыг түгээх хүрээнд цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг шинэ арга зүйд сургах, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх багшийн мэргэжил дээшлүүлэх хэрэгцээний судалгааны үндсэн дээр хүүхдийн авьяас, ур чадвар, онцлогийг нээн хөгжүүлэх, багшийн мэргэжил, ур чадварыг хөгжүүлэх сургалтын хөтөлбөр, модуль, мэдээллийн болон хэрэглэгдэхүүний цахим сан бий болгох ажлыг үргэлжлүүлнэ.
- ✓ Хүүхэд нэг бүрийн хөгжлийг дэмжих тэргүүн туршлага, шинэ технологийг бий болгох, дамжуулах, түгээн дэлгэрүүлэлтийг хэрэгжүүлнэ.

Үргэлжлэл

- ✓ Олон улсын жишигт нийцсэн шинэ арга зүй, сургалтын технологийг 2015–2016 оны хичээлийн жилээс эхлэн үндэсний хэмжээнд нэвтрүүлэхтэй холбоотой шинэ сурах бичиг, багшийн ном, гарын авлагуудыг хэвлэн түгээнэ.
- ✓ Дээд боловсролын салбарт бодлогын шинэчлэлийг үргэлжлүүлж, өрсөлдөх чадвартай Монгол иргэнийг төлөвшүүлэхэд чиглүүлнэ. Багш, инженер бэлтгэх чиглэлийн сургуулиудын хөтөлбөрийг олон улсын магадлан итгэмжлэлд хамруулах, суралцагчдад сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлнэ. Дээд боловсролын удирдлага, мэдээллийн үндэсний системийг хөгжүүлнэ. Сургалтын төрийн сангийн санхүүжилт, Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээр, хөтөлбөрийн хүрээнд дэлхийн шилдэг сургуулиудад оюутан сургана.
- ✓ Япон Улсын Засгийн газрын зээлийн хөрөнгөөр коосэн хөтөлбөр, хамтарсан бакалаврын хөтөлбөр, судлаач багш нар, магистр, докторын сургалтад оюутныг сургах арга хэмжээг үргэлжлүүлнэ.
- ✓ Шинжлэх ухааны ажилчдын ур чадвар, үр дүнд суурилсан үнэлгээ, урамшууллын тогтолцоог нэвтрүүлнэ. Мөн судалгаанд суурилсан их сургуулийн тогтолцоонд шилжих үйл ажиллагааг дэмжихийн зэрэгцээ багийн болон өрсөлдөөний зарчимд тулгуурласан төслийн сонгон шалгаруулалт, менежментийг нэвтрүүлж судалгаа шинжилгээний ажлын чанарыг сайжруулна.
- ✓ Шинжлэх ухааны парк байгуулах ажлын хүрээнд хийгдсэн судалгааны ажлуудыг үргэлжлүүлж, шинжлэх ухааны парк байгуулах хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, техник эдийн засгийн үндэслэл, ерөнхий төлөвлөгөө боловсруулна.
- ✓ Шинжлэх ухаан, технологийн эрх зүйн орчныг сайжруулна.
- ✓ “Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг 2007–2020 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөө”-ний III үе шатыг хэрэгжүүлнэ
- ✓ Монгол Улсын насанд хүрсэн иргэн, хуулийн этгээд, төрийн албан хаагч нарт цахим гарын үсэг олгох ажлыг үргэлжлүүлнэ.
- ✓ Бүх нийтийг хамарсан биеийн тамир, спортын арга хэмжээ, тэмцээн наадмын зохион байгуулалтын тогтолцоог боловсронгуй болгоно.
- ✓ Хүүхэд, залуучуудад зориулсан спорт үйлчилгээний цогцолбор, усан бассейн байгуулна
- ✓ Төр, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын түншлэлийг хөгжүүлэх замаар биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн бүх шатны магадлан итгэмжлэлийг эхлүүлнэ.
- ✓ Соёлын биет бус өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.

## 1.4.2.Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал

**ЗОРИЛТ**
**2016**

- Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх ажлыг эрчимжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- Нийгмийн даатгал, нийгмийн хамгааллын салбарт хийх шинэчлэлийн бодлогыг үргэлжлүүлнэ.

**ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**
**2016**

- ✓ Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ажиллах хүчнийг бий болгоход түлхүү анхаарч, бүтээн байгуулалтын томоохон төсөл, хөтөлбөрүүдэд үндэсний ажиллагчдыг ажиллуулж, бүтээмжтэй, тогтвортой ажлын байр бий болгоно.
- ✓ Хөдөлмөрийн хөлсийг цагаар олгох зохистой хэлбэрийг судалж, цалингийн хэмжээг инфляцийн түвшин, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан индексжүүлэн нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- ✓ Нийгмийн даатгалын эрх зүйн орчинг шинэчлэх зорилгоор тэтгэврийн даатгалын тогтолцоог олон давхаргат даатгалын тогтолцоонд шилжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- ✓ Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамрагдах хувийг нэмэгдүүлнэ.
- ✓ Нийгмийн даатгалын зарим төрлийг хувийн амьдралын даатгалд шилжүүлэх замаар урт хугацаны болон хувийн тэтгэврийн даатгалын зах зээлийг хөгжүүлнэ.
- ✓ Нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын дэвтрийг цахим хэлбэрт шилжүүлнэ.
- ✓ Өрхийн даатгалыг нэвтрүүлэн, эрүүл мэндээс үүсэх эрсдэлийг хамгаалах зорилгоор урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих эрх зүйн орчин бүрдүүлнэ.
- ✓ Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өнчин хүүхэд зэрэг зорилтот бүлэгт чиглэсэн бодлогыг дэмжинэ. Халамжийн үйлчилгээний

Үргэлжлэл

зохион байгуулалт, менежментэд хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудыг татан оролцуулж, ахмадуудаа халамжлах, ач санах хууль боловсруулна.

- ✓ Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сүлжээнд сумдын мэдээллийг холбох үйл ажиллагааг үе шаттай хэрэгжүүлнэ.
- ✓ "Хүүхэд гэр бүлийн хөгжлийн шаталсан хөтөлбөр"–ийг боловсруулж хэрэгжүүлнэ.
- ✓ Хүүхэд хамгааллын тусламжийн цогц, шуурхай үйлчилгээг хөгжүүлэх ажлын хүрээнд хүүхдийн тусламжийн утсанд ирсэн дуудлагаас шууд яаралтай тусламж үзүүлж, хариу арга хэмжээ авна.
- ✓ Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд ахмадуудыг зуучлан хамруулах, богиносгосон цагаар ажиллах боломжийг бүрдүүлэх.
- ✓ –Өрхийн мэдээллийн нэгдсэн санд үндэслэн өрхийн амьжиргааны түвшнээр ангилсан шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлнэ.

## 1.4.3. Эрүүл мэнд

**ЗОРИЛТ**

**2016**

- Эх орондоо эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээг чанарын өндөр түвшинд хийх боломжийг бүрдүүлнэ.

**ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**

**2016**

- ✓ 2016 онд эрүүл мэндийн салбарт эмнэлгийн тусламж, үйлчилгээний зохион байгуулалтыг оновчтой болгох, эмнэлгийн салбарын засаглал, хяналт, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох, тусламж, үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, салбарын санхүүжилт, хөрөнгө оруулалтын цогц төлөвлөлтийн тогтолцоог бий болгох, хувийн салбарын үүрэг, зохицуулалтыг тодорхой болгож, тусламж, үйлчилгээний ачааллыг зохистой болгох, хүн амын хэрэгцээг хэрхэн хангаж байгаа, тэдгээрийн хүчин чадлын мэдээ, мэдээллийн санг бүрдүүлэх чиглэлээр ажиллана.
- ✓ Эх орондоо чанартай, оношилгоо эмчилгээ хийлгэх нөхцөлийг бүрдүүлэх зорилтыг хэрэгжүүлэхэд эмнэлгийн тусламж, үйлчилгээний технологийн шинэчлэлийн чиглэлээр тодорхой бодлогын арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлнэ.
- ✓ Эмнэлгийн тусламж, үйлчилгээний төвлөрлийг сааруулах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлж, төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд бусад орны үйлчлүүлэгчдэд тусламж үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлж бодлогоор дэмжинэ.
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн эмнэлгүүдийг хувьчлалын аль нэг хэлбэрт шилжүүлэхгүйгээр эмнэлгийн засаглал, санхүүгийн удирдлагын үйл ажиллагаанд хамт олон, үйлчлүүлэгчдийн оролцоог хангах эрх зүйн орчныг бүрдүүлж, удирдах зөвлөлийг ажиллуулах, эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтны томилгоог ил тод, карьерын тогтолцоонд тулгуурлах эрх зүйн орчинг бүрдүүлэх, магадлан итгэмжлэлийн болон тусгай

Үргэлжлэл

зөвшөөрөл олгох эрх зүйн орчинг шинэчилж, магадлан итгэмжлэх үйл ажиллагааг хөндлөнгийн бие даасан байгууллагаар гүйцэтгүүлэх, хүн амын эрүүл мэндийн хэрэгцээ, өвчлөлийн чиг хандлага, төр, хувийн хэвшлийн зохистой харьцаатай уялдуулан эрүүл мэндийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгодог болох замаар хувийн хэвшлийг хөгжүүлнэ.

- ✓ Эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг бууруулах замаар эх, хүүхдийн эндэгдлийг тогтвортой бууруулна. Хүнсийг баяжуулахтай холбоотой эрх зүйн орчинг бүрдүүлж, баяжилт хийх хүнсний нэр төрлийг нэмэгдүүлж, хүн амын амин дэм, бичил бодисын дутлын түвшинг тогтвортой түвшин /5 хувь/-д хүрэх хүртэл нэн шаардлагатай хүн амын бүлгийг баяжуулсан хүнс, амин дэм, бичил бодисын бэлдмэлээр хангана.
- ✓ Халдварт өвчний тархалтыг бууруулахын тулд вакцин, биобэлдмэлийн хэрэгцээг бага зардлаар найдвартай хангах үүднээс биобэлдмэлийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, олон улсын байгууллагын дэмжлэг зогсоход үүсэх санхүүгийн эрсдэлээс сэргийлж, ХДХВ/ДОХ, сүрьеэгийн өвчний оношилгоо, эмчилгээний зардлыг үе шаттайгаар улсын төсөвт тусгах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.
- ✓ Эмийн аюулгүй байдлын мэдээллийн нэгдсэн тогтолцоог нэвтрүүлж, эмийн чанар, аюулгүй байдлыг хангахад эм үйлдвэрлэгч, импортлогч, ханган нийлүүлэгч, бүртгүүлэгчийн эрх үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, эмийг зах зээлд нэвтэрсний дараа тандаж судлах шаардлагатай тохиолдолд эргүүлэн татах, буцаах, эмийн чанарыг олон улсын стандартыг хангасан хөндлөнгийн итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүнгээр баталгаажуулах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

## 1.5. Бүс нутаг, байгаль орчин, аялал жуулчлалын салбарын төлөв 2016 онд

**ЗОРИЛТ**

**2016**

- Хөдөөгийн хөгжлийг дэмжиж, хүн амын амьдрах орчныг сайжруулна.
- Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлнэ.

**ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**

**2016**

- ✓ Бүх аймгуудын төвийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбосноор хот, хөдөөгийн хоорондын харилцаа холбоо түргэн шуурхай болж, бараа, бүтээгдэхүүний тээврийн зардал багасах нөхцөлийг бүрдүүлнэ.
- ✓ Орон нутагт малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрийг бий болгож, шинээр ажлын байр бий болгох зорилт тавин ажиллаж байна. Улмаар хөдөө, орон нутагтаа ажилтай, орлоготой иргэдийн амьдралын баталгааг хангах юм. Ингэснээр байнгын орлоготой айл өрх олноор бий болж, нийслэл хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн багасна.
- ✓ Эрчим хүч, бензин, дизелийн түлшний үнийг улсын хэмжээнд ижил байх эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
- ✓ Бүх сумд, тосгонд үүрэн телефоны утас, утасгүй интернетэд холбогдсоноор орон нутгийн иргэд мэдээллээс хоцрох гэдэг асуудалгүй болоод байна. Бүх аймаг, сумын төвд алсын зайнаас мэргэжлийн өндөр түвшний сургалтыг авах нөхцөл бүрдээд байна.
- ✓ Хөдөө, орон нутагт орчин үеийн оношилгооны төвүүд байгуулж, телемедицины сүлжээнд холбон, зайнаас оношлох, зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах үйл ажиллагааг тогтмолжуулснаар орон нутгаас нийслэлд оношилгоо, шинжилгээ хийлгэхээр ирэх иргэдийн тоо буурах төдийгүй орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын чадавх сайжирч, тусламж үйлчилгээний төвлөрөл саарч байна.
- ✓ Бүх сумдад мал аж ахуйн бараа, түүхий эд бэлтгэх үндэсний сүлжээ бий болгоно.
- ✓ Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай үйлдвэрлэл, хэрэглээг

Үргэлжлэл

хөгжүүлнэ. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэн орчны бохирдол, доройтлыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална. Ногоон ажил эрхлэлтийг дэмжиж, ядуурлыг бууруулан ногоон амьдралын хэв маягийг төлөвшүүлнэ. Байгальд зохицсон ахуй, соёлын үнэт зүйлсийг хөгжүүлж, боловсрол, шинжлэх ухаан, технологи, инновацийг ногоон хөгжлийн хурдасгуур болгоно. Уур амьсгалын өөрчлөлт, бүс нутгийн байгалийн нөөц баялаг, сэргээх чадавхид нийцүүлэн хүн амын суурьшлыг төлөвлөн хөгжүүлнэ.

- ✓ Монгол Улсын нөхцөлд тохирсон ногоон хөгжлийн загвар, хэм хэмжээг эдийн засаг, нийгмийн бүхий л салбарт бий болгож, ногоон хөгжлийг хангахад чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлж, эдийн засгийн урт хугацааны тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажлыг идэвхтэй өрнүүлнэ.
- ✓ Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
- ✓ Хог хаягдлыг дахин боловсруулж, эрчим хүч үйлдвэрлэх эко цогцолбор байгуулна.
- ✓ Бороо, цасны усыг хуримтлуулах хөв цөөрөм байгуулах, булаг шандны эхийг хашиж хамгаалах ажлыг зохион байгуулна.
- ✓ Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлнэ.
- ✓ Туул усан цогцолбор, Орхоны шинэ нуур, Шүрэнгийн УЦС–ын ажлын зураг төслийг боловсруулна.
- ✓ Гидрогеологийн зураглал, ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийн хайгуул, судалгааг хийнэ.
- ✓ Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар, аялал жуулчлалын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх хүрээнд “Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”–ийг боловсруулж, хэрэгжүүлнэ. Мөн аялал жуулчлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг Улсын Их Хурлаар хэлэлцүүлж батлуулна.
- ✓ ITB Берлин 2015 оны үзэсгэлэнгийн үр дүнгээс харахад одоогоор Монгол Улсад 150000–аас доошгүй жуулчин ирэх гэрээ хэлцэл хийгдсэн байна. Дэд бүтэц, ялангуяа гадаад, дотоодын агаарын тээврийн үйлчилгээний давтамжийг нэмэгдүүлэх, шинэ шугам нээх арга хэмжээ авч, аялал жуулчлалын салбарын хөгжлийг эрчимжүүлнэ.
- ✓ Аялал жуулчлалын гол үйлчилгээний нэг болох хөтөч тайлбарлагчийн чадавх, үйлчилгээний чанар стандартыг мөрдүүлнэ.

# 1.6. Гадаад бодлого, батлан хамгаалах салбар 2016 онд

**ЗОРИЛТ**

**2016**

- Энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт, идэвхтэй гадаад бодлого явуулна.
- Батлан хамгаалахын чадавхыг нэмэгдүүлж, улс орны бүтээн байгуулалтад оролцох боломжийг дээшлүүлнэ.

**ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**

**2016**

✓ 2016 онд гадаад харилцааны салбарт хийгдэх том ажил бол Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалтыг Улаанбаатар хотод зохион байгуулах явдал юм. Энэхүү дээд түвшний уулзалтыг сайтар бэлтгэж зохион байгуулах ажил нь Монгол Улсын төр, засгийн бүх байгууллагын анхаарал, оролцоо, хүчин чармайлтын үр дүнд хэрэгжинэ. Үүний зэрэгцээ гадаад харилцааны чиглэлээр явуулж байгаа уламжлалт бодлого, үйл ажиллагааг идэвхжүүлэх болно.

✓ Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх урт хугацааны бодлогын баримт бичгийн үндсэн арга хэмжээний хэрэгжилтийг хангах, салбарын цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, тулгамдаж буй асуудлуудыг оновчтой шийдвэрлэх зорилгоор Батлан хамгаалах салбар "батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлж, мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг төлөвшүүлэн, албан хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах" гэсэн зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Олон улсын болон бүс нутгийн аюулгүй байдлын орчны төлөв, өөрчлөлтийн хандлагад нийцсэн батлан хамгаалах бодлого, зорилтыг тодорхойлж, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх.
- Батлан хамгаалах гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, дэлхийн болон бүс нутгийн орнуудтай цэргийн итгэлцлийг бэхжүүлэх.
- Энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх зориулалт бүхий 3 дахь батальоны үүрэг гүйцэтгэх бэлтгэлийг хангуулах, шаардлагатай зэвсэглэл, техникээр хангах, улмаар энхийг дэмжих ажиллагаанд оролцох Монгол Улсын Зэвсэгт хүчний оролцоог нэмэгдүүлж, энхийг дэмжих ажиллагаанд оролцох Мотобуудлагын бригадыг байгуулах.
- Зэвсэгт хүчнийг улс орны хэмжээний томоохон бүтээн байгуулалтад оролцуулах оролцоог нэмэгдүүлэх зэрэг болно.

# 1.7. ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛИЙН ТӨЛӨВ 2016 ОНД

**ЗОРИЛТ**

**2016**

- Хууль тогтоомж, эрх зүйн шинэчлэлийн бодлогыг дэмжих ажлыг үргэлжлүүлнэ.
- Гамшгаас хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, мэргэжлийн байгууллагын бие бүрэлдэхүүн, аврагчийн бие бялдрын тэсвэр хатуужил, сэтгэл зүйн бэлтгэлийг төлөвшүүлнэ.

**ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ**

**2016**

- ✓ Эрх зүйн салбарын шинэтгэлийн бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, хууль зүйн боловсрол, эрх зүйн сургалт, мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулна. Шүүх эрх мэдлийн, хууль сахиулах байгууллагын, хүний эрхийг хангах чиглэлээр болон эрх зүйн шинэтгэлийн бодлогын хүрээнд хууль тогтоомжийн төсөл боловсруулж, үр нөлөөг тандан судална. Монгол Улсын хууль тогтоомж, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний болон захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын нэгдсэн сан болон бүртгэлийг эрхлэн хөтөлнө. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, зохицуулах ажлыг үргэлжлүүлнэ.
- ✓ Гамшгаас хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.
- ✓ Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор уршгийг арилгах, аврах, гал унтраах ангийн чадавхыг сайжруулна.
- ✓ Онцгой байдлын албаны гал унтраах техник, тоног төхөөрөмжийг сайжруулах төсөл хэрэгжүүлнэ.
- ✓ Мэргэжлийн байгууллагын бие бүрэлдэхүүн аврагчдын дайчилгааны дараах бие бялдар, сэтгэл зүйл бэлтгэлийг төлөвшүүлнэ.
- ✓ Архивын шинэ барилга, төрийн албан хаагчийн нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн зардал, түүнчлэн шинээр баригдаж буй хорих ангийн барилга, Хан-Уул дүүрэгт баригдаж буй шүүх, прокурорын барилгын санхүүжилтийг тус тус шийдвэрлэнэ.

# II ХЭСЭГ

# АЛБАН МЭДЭЭЛЭЛ, ХАВСРАЛТУУД



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

*2015 оны 6 дугаар сарын 11-ний өдөр* *Дугаар 52* *Улаанбаатар хот*

## МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2016 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.

2.“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”, Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай болон бусад бодлогын баримт бичиг, хөтөлбөртэй нягт уялдуулан хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/, Монголбанк /Н.Золжаргал/, Санхүүгийн зохицуулах хороо /З.Нарантуяа/ болон холбогдох бусад байгууллагад үүрэг болгосугай.

3.Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг боловсруулах, хэлэлцэх, хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй уялдуулан эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахыг Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо /А.Бакей/-нд даалгасугай.

4.Үндсэн чиглэлийн биелэлтэд гүйцэтгэлийн аудит хийхдээ Төрийн аудитын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасан зарчмыг баримтлан, биелэлтийг албан тушаалтны үүрэг,

хариуцлагатай холбон дүгнэж байхыг Үндэсний аудитын газар /А.Зангад/-т үүрэг болгосугай.

5.“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т даалгасугай:

1/Тухайн жилд хэрэгжих боломж, бодит байдлыг харгалзан, зорилт, арга хэмжээ бүрийн хүрэх түвшин, түүний биелэлтийг дүгнэх шалгуур үзүүлэлтийг тодорхой болгох, үргэлжлүүлэн санхүүжүүлэх зорилт, арга хэмжээнд шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг дараа жилийн төсвийн тухай хуульд нэмж тусгаж байх;

2/Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцад тавих дотоодын байнгын хяналтыг сайжруулах, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх Засгийн газрын байгууллагуудын чадавхыг сайжруулах арга хэмжээ авах;

3/Төрийн байгууллагуудын ажлын хариуцлагыг дээшлүүлэх, төрийн албаны шат бүрд ажлын гүйцэтгэл, үр дүнг тогтмол үнэлдэг тогтолцоог бий болгох.

**МОНГОЛ УЛСЫН**
**ИХ ХУРЛЫН ДАРГА З.ЭНХБОЛД**

Улсын Их Хурлын 2015 оны
52 дугаар тогтоолын хавсралт

# МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2016 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

| Д/д | Урт болон дунд хугацааны хөтөлбөр, бодлогын баримт бичиг | Зорилт, арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | 2016 онд хүрэх түвшин, үр дүн | 2016 онд шаардлагатай хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /тэрбум төгрөг/ | Хариуцах байгууллага |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **НЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО** | | | | | | |
| **Зорилт 1.Эдийн засгийн хүндрэлийг даван туулж, макро эдийн засгийг тогтворжуулах бодлого баримтална.** | | | | | | |
| 1.1 | “Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого” /цаашид “ҮХЦБ” гэх/-ын 5.1 дэх заалт | Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах | Дотоодын нийт бүтээгдэхүүн / цаашид “ДНБ” гэх/-ий бодит өсөлт, хувиар | 5.0 | - | Сангийн яам/цаашид “СЯ” гэх/, Бусад бүх яамд |
| | | | Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ, ам.доллар | 4400 | - | |
| 1.2 | “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” /цаашид “ЗГҮАХХАХТ” гэх/-ний 145 дахь заалт | Ажлын байрыг хадгалах зарчим баримталж, ажилгүйдлийн түвшинг бууруулах | Ажилгүйдлийн түвшин, хувиар | 7.0 | - | Хөдөлмөрийн яам / цаашид “ХЯ” гэх/, Бусад бүх яамд |
| 1.3 | ЗГҮАХХАХТ-ний 12.1 дэх заалт | Инфляцийг онилсон мөнгөний бодлого хэрэгжүүлэх | Инфляцийн зорилтот төвшин, оны эцэст | Нэг оронтой тоонд байлгах | - | Монголбанк |
| 1.4 | ҮХЦБ-ын 5.1.3 дахь зорилт | Төлбөрийн тэнцлийг алдагдалгүй болгох бодлого баримтлах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | Монголбанк, Бүх яамд |
| 1.5 | ЗГҮАХХАХТ -ний 1.1 дэх заалт | Татварын шинэчлэлийг гүнзгийрүүлж, энгийн ойлгомжтой, олон улсын жишигт нийцүүлэх замаар бизнес эрхлэгч, бага орлоготой иргэдийг дэмжих | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | СЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1.6 | ҮХЦБ-ын 5.1.4 дэх заалт, Өрийн удирдлагын тухай хуулийн 14.2 дахь хэсэг | Өрийн удирдлагын дунд хугацааны стратегийг хэрэгжүүлж, дунд хугацаанд учирч болзошгүй төлбөрийн эрсдэлийг бууруулах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | СЯ |
| 1.7 | ҮХЦБ-ын 5.1.1 дэх заалт, ЗГҮАХХАХТ-ний 13.1, 13.2 дахь заалт | Макро эдийн засгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн төсвийн бодлогыг хэрэгжүүлэх | ДНБ-д нэгдсэн төсвийн орлогын эзлэх доод хэмжээ, хувиар | 24.6 | - | СЯ |
| | | | ДНБ-д нэгдсэн төсвийн зарлагын эзлэх дээд хэмжээ, хувиар | 28.6 | - | |
| | | | Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн ДНБ-д эзлэх хэмжээ, хувиар | -4.0 | - | |
| **Зорилт 2. Санхүүгийн эх үүсвэрүүдийг бүрэн дайчилж, үр ашгийг дээшлүүлэх замаар хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.** | | | | | | |
| 2.1 | ҮХЦБ-ын 5.1.5, 2.2.1 дэх зорилт, ЗГҮАХХАХТ-ний 28 дахь заалт | Хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээж, хөрөнгө оруулалтыг татах, хөрөнгө оруулалтын орчныг сурталчлах цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх | Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ, тэрбум ам.доллар | 1.8 | - | Хөрөнгө оруулалтын газар /цаашид “ХОГ” гэх/, Уул уурхайн яам, /цаашид “УУЯ” гэх/ |
| 2.2 | ЗГҮАХХАХТ-ний 24 дэх заалт | Орон нутгийн хөгжлийн сангийн үр өгөөж, ашиглалтыг сайжруулах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | СЯ, Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар /цаашид “АНЗДТГ” гэх/ |
| 2.3 | Өрийн удирдлагын тухай хуулийн 9.1.13 дахь заалт | Засгийн газрын өрийн баталгааны сангийн эрх зүйн орчныг боловсронгуй болгож, үйл ажиллагааг эхлүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | СЯ |
| 2.4 | ЗГҮАХХАХТ-ний 51.1 дэх заалт, Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого /цаашид “ТЭБСББ” гэх/-ын 3.3.2 дахь заалт | Оюу толгойн далд уурхайн хөрөнгө оруулалтын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх | Ажлын явц, хувиар | 20-иос дээш | - | Монгол Улсын сайдын Ажлын алба УУЯ |
| 2.5 | ЗГҮАХХАХТ-ний 52 дахь заалт | Таван толгойн төслийг үргэлжлүүлэх | Ажлын явц, хувиар | 20.0 –иос дээш | - | Монгол Улсын сайдын Ажлын алба, УУЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2.6 | Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөрийн 11.3 дахь заалт/ цаашид "ЭЗХГАХХ" гэх/ | Үндэсний давхар даатгалын корпораци байгуулах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | СЯ, Санхүүгийн зохицуулах хороо /цаашид "СЗХ" гэх/ |
| 2.7 | ЗГҮАХХАХТ-ний 35 дахь заалт | Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг жигдрүүлж, эдийн засгийг дэмжих | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | СЯ, СЗХ |
| 2.8 | Экспортыг дэмжих хөтөлбөрийн 3.1 дэх заалт | Тоног, төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлэх замаар үндэсний үйлдвэрлэлийг дэмжих | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | Аж үйлдвэрийн яам / цаашид "АҮЯ" гэх/, СЯ, Хөгжлийн банк |
| 2.9 | ЭЗХГАХХ-ийн 2.2 дахь заалт | Банкны салбарт эрсдэл хуримтлагдах, зээлийн тасалдал үүсэх, системийн шинжтэй тогтворгүй байдал бий болохоос сэргийлэх арга хэмжээ авах | Нийт зээлийн өрийн үлдэгдэлд чанаргүй зээлийн эзлэх хувь | 5.0-аас доош | - | Монголбанк |
| 2.10 | ЗГҮАХХАХТ -ний 35.2 дахь заалт | Нийгмийн даатгалын зарим төрлийг хувийн амьдралын даатгалд шилжүүлэх замаар урт хугацааны болон хувийн тэтгэврийн даатгалын зах зээлийг хөгжүүлэх | Хууль эрх зүйн орчин бүрдүүлэх ажлын явц, хувиар | 100.0 | - | СЗХ, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам /цаашид "ХАХНХЯ" гэх/ |
| 2.11 | ҮХЦБ-ын 4.7.1 дэх заалт, ЗГҮАХХҮАТ-ний 128.1 дэх заалт | Үйлдвэрлэлийн орц болох эрчим хүч, материал, усыг үр ашигтай хэмнэлттэй болгох төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх | Төлөвлөгөө боловсруулах ажлын явц, хувиар | 100.0 | - | АҮЯ, ЭХЯ, БОНХАЖЯ |
| 2.12 | ҮХЦБ-ын 5.1.5 дахь заалт | Бизнесийн орчин, эдийн засгийн эрх чөлөөний, өрсөлдөх чадварын зэрэг олон улсын байгууллагуудаас гаргасан индексээр Монгол Улсын өнөөгийн байр суурийг сайжруулах цогц төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх | Төлөвлөгөө боловсруулах ажлын явц, хувиар | 100.0 | - | СЯ, АҮЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 3. Гадаад худалдааны таатай орчныг бүрдүүлж, экспортыг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.** | | | | | | |
| 3.1 | ЭЗХГАХХ-ийн 10.5 дахь заалт | Тарифын болон тарифын бус саад тотгорыг бууруулж, хөрш болон гуравдагч орны зах зээлд хөнгөлөлттэй нөхцөлөөр бараа, бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг бүрдүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | АҮЯ, Гадаад хэргийн яам / цаашид "ГХЯ" гэх/ |
| 3.2 | ЗГҮАХХАХТ-ний 61.1 , 61.2 дахь заалт | Дэлхийн худалдааны байгууллагатай тохирсон хэмжээнд багтаан импортын зарим бараанд ногдуулах гаалийн татварыг нэмэгдүүлж, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | СЯ, АҮЯ |
| 3.3 | ЗГҮАХХАХТ-ний 58 дахь заалт | "Замын-Үүд" эдийн засгийн чөлөөт бүс, "Алтанбулаг" болон "Цагааннуур" худалдааны чөлөөт бүсүүдийн дэд бүтцийг барьж байгуулах | Дэд бүтцийн ажлын явц, хувиар | 50.0 | 90.0 Төр хувийн хэвшлийн түншлэл / цаашид "ТХХТ" гэх/ | АҮЯ |
| 3.4 | ЗГҮАХХАХТ-ний 8.5 дахь заалт | Гадаад худалдааг хөнгөвчлөх "Цахим нэг цонх" хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх | Хөтөлбөрийг боловсруулж батлуулах ажлын явц, хувиар | 100.0 | - | АҮЯ |
| **ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРУУДЫН БОДЛОГО** | | | | | | |
| **Зорилт 4.Мал аж ахуй, газар тариалангийн салбарын хөгжлийг эрчимжүүлэх бодлого хэрэгжүүлнэ.** | | | | | | |
| 4.1 | "Монгол мал" үндэсний хөтөлбөрийн 3.2.1, 3.2.3 дахь заалт | Үржлийн цөм сүргийн малын тоог нэмэгдүүлэх | Үржлийн үзлэг ангилалтад хамрагдах өсвөр малын тооны өсөлт, хувиар | 20.0-иос доошгүй | 0.2 Улсын төсөв | Хүнс, хөдөө аж ахуйн яам /цаашид "ХХААЯ" гэх/, АНЗДТГ |
| | | | Стандартад нийцэж баталгаажсан хээлтүүлэгчийн тооны өсөлт, хувиар | 20.0-иос доошгүй | | |
| 4.2 | "Монгол мал" үндэсний хөтөлбөрийн 3.2 дахь заалт | Төв, суурин газрын ойролцоо мах, сүүний чиглэлийн хонь, үхрийн болон гахай, шувууны фермерийн аж ахуй байгуулж, дотоодын хэрэгцээг хангах, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх | Эрчимжсэн мал аж ахуйн бүтээгдэхүүний өсөлт, хувиар | 20.0 | 2.5 Хувийн хэвшил | ХХААЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4.3 | “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 3.2 дахь заалт | Монгол малын генийн санг хамгаалах, малын нөхөн үржилд биотехнологийн ололтыг нэвтрүүлэх ажлын цар хүрээг нэмэгдүүлэх | Малын удмын сангийн үндэсний цогцолбор барих ажлын явц, хувиар | 100.0 | 1.3<br>Улсын төсөв | ХХААЯ |
| 4.4 | “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 3.4 дэх заалт | Улсын тусгай хэрэгцээнд авах отрын бэлчээрийн талбайн ашиглалтыг сайжруулах, аймаг дундын болон сум дундын отрын бүсийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх | Тусгай хэрэгцээнд шинээр авах бэлчээрийн талбайн хэмжээ, мянган га | 50 –иас доошгүй | 0.3<br>Улсын төсөв | ХХААЯ |
| | | | Мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх ажлын явц, хувиар | 100.0 | | |
| 4.5 | “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн 3.3.1 дэх заалт, ЗГҮАХХАХТ-ний 78.9, 168.3 дахь заалт | Малын гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал сүргийг эрүүлжүүлэх | Эрүүлжүүлэх арга хэмжээнд хамрагдах малын тоо | 20.0 саяас доошгүй | 8.0<br>Улсын төсөв | ХХААЯ |
| 4.6 | ЗГҮАХХАХТ-ний 93 дахь заалт | Газар тариалангийн техник, тоног төхөөрөмжийг бага хүүтэй, урт хугацаатай зээлээр худалдан авах нөхцөлийг бүрдүүлэх | Техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлын явц, хувиар | 75.0 | 10.0<br>Гадаад эх үүсвэр | ХХААЯ |
| 4.7 | ЗГҮАХХАХТ-ний 93 дахь заалт,<br>“Чацаргана” Үндэсний хөтөлбөр, ҮХЦБ-ын 5.2.1.4.5 дахь зорилт | Чихрийн манжин тариалж, элсэн чихэр үйлдвэрлэх, чацаргана болон бусад жимсний тариалалтыг нэмэгдүүлэх үйл ажиллагааг бодлогоор дэмжих | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | ХХААЯ |
| **Зорилт 5. Экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжинэ.** | | | | | | |
| 5.1 | ЗГҮАХХАХТ-ний 99.1 дэх заалт | Газрын тос боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах | ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын явц, хувиар | 100.0 | 14.0<br>Хувийн хэвшил,<br>Гадаад эх үүсвэр | АҮЯ,<br>УУЯ |
| 5.2 | ЗГҮАХХАХТ-ний 49.3 дахь заалт | *Зэс хайлуулах үйлдвэрийн санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх* | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | АҮЯ,<br>УУЯ |
| 5.3 | ЗГҮАХХАХТ-ний 103 дахь заалт | Нүүрсийг шингэрүүлэх, хийжүүлэх, хуурай аргаар боловсруулах үйл ажиллагааг бодлогоор дэмжих | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | УУЯ,<br>АҮЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 5.4 | ЗГҮАХХАХТ-ний 30.2 дахь заалт | Оёмол, нэхмэл, сүлжмэл бүтээгдэхүүн, ноос, ноолуур боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх | Нийт үйлдвэрлэлийн хэмжээний өсөлт, хувиар | 20.0 | 30.0<br>Хөгжлийн банк | АҮЯ,<br>СЯ |
| 5.5 | ЗГҮАХХАХТ-ний 68.1, 69.3 дахь заалт | Арьс, ширийг дотооддоо гүн боловсруулах болон түүгээр бэлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үндэсний үйлдвэрлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгох | Арьс ширийг дотоодод боловсруулах хувь | 60.0 | 80.0<br>Хөгжлийн банк | АҮЯ |
| 5.6 | ЗГҮАХХАХТ-ний 76 дахь заалт | Хоногт 2-5 тонн сүү хөргөх хүчин чадалтай хөргөлтийн төвүүдийг байгуулах | Байгуулах хөргөлтийн төвийн тоо | 50 | 7.0<br>Гадаад эх үүсвэр | ХХААЯ |
| 5.7 | ЗГҮАХХҮАТ-ний 103.1 дэх заалт | Цахилгаан эрчим хүч, ган, нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх, экспортлох асуудлаар харилцагч талтай хэлэлцээр хийх, бодлогыг Улсын Их Хуралд танилцуулах | Хэлэлцээр байгуулах ажлын явц, хувиар | 100.0 | - | АҮЯ,<br>Эрчим хүчний яам /цаашид “ЭХЯ” гэх/,<br>УУЯ,<br>Байгаль орчин, ногоон хөгжил, аялал, жуулчлалын яам /цаашид БОНХАЖЯ гэх/ |
| 5.8 | ЗГҮАХХҮАТ-ний 67.10 дахь заалт | Шивээ-Овоогийн нүүрсний уурхайд цахилгаан станц байгуулж эрчим хүч экспортлох чиглэлээр холбогдох талтай хэлэлцээ хийх | Хэлэлцээр байгуулах ажлын явц, хувиар | 100.0 | - | ЭХЯ,<br>УУЯ |
| 5.9 | ЗГҮАХХҮАТ-ний 60.1 дэх заалт | Уул уурхайн бус салбарыг хөгжүүлэх, дэмжих үндэсний хөтөлбөрийг 2016 оны эхний хагас жилд багтаан боловсруулж батлуулах | Хөтөлбөр боловсруулах ажлын явц, хувиар | 100.0 | - | АҮЯ,<br>ГХЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 6.Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана.** | | | | | | |
| 6.1 | ЗГҮАХХАХТ-ний 34.20 дахь заалт,<br>Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн 5.4.7 дахь заалт | Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төв байгуулах | Байгуулах төвийн тоо | 5 | 0.6<br>Улсын төсөв<br>5.0<br>ТХХТ | АҮЯ,<br>АНЗДТГ |
| 6.2 | ЗГҮАХХАХТ-ний 35.9 дэх заалт,<br>Жижиг дунд үйлдвэрийг дэмжих хөтөлбөрийн 5.5.3 дахь заалт | Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг эрчимжүүлэх | Дэмжлэгт хамрагдах аж ахуйн нэгжийн тоо | 80-аас доошгүй | - | АҮЯ,<br>СЯ |
| **Зорилт 7.Бодит салбарын өсөлтийг хангах эрчим хүчний бодлогыг хэрэгжүүлж, шинэ эх үүсвэрүүдийн барилгын ажлыг эхлүүлнэ.** | | | | | | |
| 7.1 | ЗГҮАХХАХТ-ний 56.1, 56.2, 67.11, 67.12 дахь заалт | Чойрын дэд станцыг өргөтгөж, Багануур-Өндөрхаан-Чойбалсан, Чойр-Сайншанд-Замын-Үүдийн 2 хэлхээт 220 кВ-ын ЦДАШ, дэд станц, Улаанбаатар-Мандалговийн 330 кВ-ын 2 хэлхээт ЦДАШ, дэд станцыг барих ажлын бэлтгэлийг хангах | ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлын явц, хувиар | 100.0 | 5.0<br>ТХХТ | ЭХЯ,<br>АҮЯ |
| 7.2 | ЗГҮАХХАХТ-ний 64.1, 64.2, 64.3 дахь заалт | “ДЦС-5”-барилгын ажил, Сонгино дэд станц хүртэлх 220 кВ-ын ЦДАШ-ын барилга угсралтын ажлыг эхлүүлж, дулаан дамжуулах магистраль шугамын зураг, төслийг боловсруулах | Барилгын ажлын явц, хувиар | 10.0 | 150.0 сая ам.доллар<br>ТХХТ<br><br>5.5<br>Гадаад эх үүсвэр | ЭХЯ,<br>АҮЯ |
| 7.3 | ЗГҮАХХАХТ-ний 65.1, 67.2, 67.3, 67.5, 67.6 дахь заалт | Бүс нутгийг эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангах хүрээнд Баруун болон Дорнод бүсийн ДЦС, Тавантолгой, Багануур, Тэлмэн, Баянтээгийн ДЦС-уудын барилгын ажлыг эхлүүлэх | Концессийн гэрээ байгуулах ажлын явц, хувиар | 100.0 | 250.0 сая ам.доллар<br>ТХХТ | ЭХЯ,<br>АҮЯ |
| | | | Барилгын ажлын явц, хувиар | 10.0 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 7.4 | ЗГҮАХХАХТ-ний 67.8 дахь заалт | Эрдэнэтийн ДЦС-ын хүчин чадлыг 30 МВт-аар нэмэгдүүлэх | Барилгын ажлын явц, хувиар | 100.0 | 42.0сая ам.доллар Гадаад эх үүсвэр | ЭХЯ |
| 7.5 | ЗГҮАХХАХТ-ний 67.10 дахь заалт | Эрчим хүчний шинэ эх үүсвэрүүдийг хангах зорилгоор Багануур, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл хэрэгжүүлэх | Хүчин чадлын нэмэгдэх хэмжээ | 2 дахин | - | ЭХЯ, УУЯ |
| 7.6 | ЗГҮАХХАХТ-ний 66.4 дэх заалт | Улаанбаатар хотын захын хорооллын 35/6 кВ-ын дэд станцуудын хүчдэлийг 35/10 кВ-д шилжүүлж, хүчин чадлыг нь нэмэгдүүлэн, 6-35 кВ-ын кабель, шугамыг өргөтгөж, шинэчлэх | Барилгын явц, хувиар | 100.0 | 0.8 Улсын төсөв | ЭХЯ |
| 7.7 | ЭЗХГАХХ-ийн 12.1 дэх заалт | Түлш, эрчим хүчний үнэ тарифыг зах зээлийн зарчмын дагуу бодит өртгийн тооцоонд үндэслэн зохицуулалт хийх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | Эрчим хүчний зохицуулах хороо |
| 7.8 | ЗГҮАХХАХТ-ний 132.2 дахь заалт | Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Дундговь, Завхан, Өвөрхангай, Хэнтий, Төв аймгийн төвүүдэд дулаан хангамжийн шинэ эх үүсвэр барих” | Барилгын ажлын явц, хувиар | 50 | - | ЭХЯ |
| 7.9 | ЗГҮАХХАХТ-ний 225 дахь заалт | Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх | Санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх ажлын явц | 100.0 | - | ЭХЯ |
| 7.10 | ЗГҮАХХАХТ-ний 225.1, “Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр”-ийн 4.2.6 дахь заалт | Эгийн голын усан цахилгаан станц, түүний дэд бүтцийг барих ажлыг эхлүүлэх | Хөрөнгө оруулалт, санхүүжилтийн ажлын явц | 100.0 | - | ЭХЯ |
| 7.11 | ЗГҮАХХАХТ-ний 253 дахь заалт | БНХАУ-тай Эрчим хүчний ерөнхий хэлэлцээр байгуулах ажлыг эрчимжүүлэх | Хэлэлцээр байгуулах ажлын явц, хувиар | 100.0 | - | ЭХЯ, ГХЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 8.Монгол Улсын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжихэд чиглэсэн тээврийн салбарыг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлнэ.** | | | | | | |
| 8.1 | ҮХЦБ-ын 5.3.1.7 дахь зорилт, ЗГҮАХХАХТ-ний 220.2 дахь заалт | Нийтийн тээврийн үйлчилгээнд тусгай замын автобусны үйлчилгээг нэвтрүүлэх төслийг эхлүүлэх | Бэлтгэл ажлын явц, хувиар | 100.0 | 2.1 сая ам.доллар Гадаад эх үүсвэр | Зам тээврийн яам /цаашид "ЗТЯ" гэх/ |
| 8.2 | ҮХЦБ-ын 5.3.1.2 дахь зорилт, Шинэ бүтээн байгуулалт дунд хугацааны зорилтот хөтөлбөр /цаашид "ШББДХЗХ" гэх/-ийн 4.4.2.10 дахь заалт, ЗГҮАХХАХТ-ний 112 дахь заалт | Азийн авто замын сүлжээнд холбогдсон АН-4 чиглэлийн авто замын сүлжээг барьж, ашиглалтад оруулах | Ярант-Ховд-Өлгий-Улаанбайшинт чиглэлийн замын урт, км | 189.7 | 37.0 Улсын төсөв | ЗТЯ |
| 8.3 | ҮХЦБ-ын 5.3.1.2 дахь зорилт, "ШББДХЗХ"-ийн 4.4.2.10 дахь заалт, ЗГҮАХХАХТ-ний 108.1, 108.4 108.8, 108.11 дэх заалт | Аймгийн төвүүдийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбох | Ховд, Увс, Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан аймгуудын чиглэлд баригдах замын урт, км | 483 | 367.0 ТХХТ | ЗТЯ, АҮЯ |
| 8.4 | ҮХЦБ-ын 5.3.1.3 дахь зорилт | Улсын чанартай авто замын сүлжээний ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах | Засвар, арчлалт хийгдэх авто замын сүлжээний урт, мян.км | 12.7 | 18.0 Улсын төсөв | ЗТЯ |
| 8.5 | ҮХЦБ-ын 5.3.1, Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого / цаашид "ТТЗТТББ" гэх/-ын 3.2.2, 3.2.4 дэх заалт, ЗГҮАХХАХТ-ний 107.1 дэх заалт | Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын 1, 2 дугаар үе шатны төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг үргэлжлүүлэх | Тавантолгой-Сайншанд чиглэлийн /435 км/<br>Сайншанд-Баруун урт-Хөөт чиглэлийн /430км/<br>Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн /415км/ Барилгын ажлын явц, хувиар | 10.0 | 600.0 сая ам.доллар ТХХТ | ЗТЯ, АҮЯ |
| 8.6 | ҮХЦБ-ын 5.3.1.4 дэх зорилт, ЗГҮАХХАХТ-ний 120.3 дахь заалт | Эрдэнэт-Овоотын 3 дугаар үе шатны төмөр замын суурь бүтцийн барилгын ажлыг эхлүүлэх | Барилгын ажлын явц, хувиар | 10.0 | 131.0 сая ам.доллар ТХХТ | ЗТЯ, АҮЯ |
| 8.7 | ЗГҮАХХАХТ-ний 107.2 дахь заалт | Мандал-Багахангай чиглэлийн Богдхан төмөр замын суурь бүтэц барих төслийг эхлүүлэх | Бэлтгэл ажлын явц, хувиар | 100.0 | 26.6 сая ам.доллар Гадаад эх үүсвэр | ЗТЯ |
| | | | Барилгын ажлын явц, хувиар | 5.0 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 8.8 | "Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого"-ын 6.1.4 дэх заалт | Даланзадгад, Ховдын нисэх буудлыг олон улсын нөөц нисэх буудал болгон өргөжүүлэх | Барилгын ажлын явц, хувиар | 10.0 | 6.0<br>ТХХТ | ЗТЯ,<br>АҮЯ |
| 8.9 | ЗГҮАХХАХТ-ний 108.29 дэх заалт | Ховдоос Завханы чиглэлийн Сархайрханы гүүр хүртэлх 130 км хатуу хучилттай замыг барих асуудлыг судалж шийдвэрлэх | Бэлтгэл ажлын явц, хувиар | 100.0 | - | ЗТЯ |
| **Зорилт 9.Геологи, эрдэс баялгийн салбарыг хөгжүүлэх замаар ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлж, гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.** | | | | | | |
| 9.1 | ҮХЦБ-ын 5.2.1.1 дэх зорилт, ЗГҮАХХАХТ-ний 38.1 дэх заалт | Нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлөвийг судлах зорилгоор 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх | Хамруулах газар нутгийн хэмжээ, хувиар | 40.0 | 10.0<br>Улсын төсөв | УУЯ |
| 9.2 | ЗГҮАХХАХТ-ний 100.1, 100.2 дахь заалт, Төрөөс газрын тосны салбарт 2017 он хүртэл баримтлах бодлого 3.5.7 дахь заалт | Газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор улсын нөөцийн агуулах барихад дэмжлэг үзүүлэх | Барилгын ажлын явц, хувиар | 50.0 | 19.0<br>ТХХТ | УУЯ,<br>АҮЯ |
| 9.3 | ТЭБСББ-ын 3.3.3 дахь заалт | Ашигт малтмалын ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах ажлыг эрчимжүүлэх | Ашиглалтад оруулах ордын тоо | 25.0-аас доошгүй | - | УУЯ |
| 9.4 | ЗГҮАХ-ийн 40.12 дахь заалт | Ашигт малтмалын төрөл, олборлох, боловсруулах технологийн онцлогийг тусгасан байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх Европын Холбооны стандартыг нутагшуулж, мөрдүүлэх | Шинээр мөрдүүлэх үндэсний стандартын тоо | 9 | - | УУЯ,<br>Стандартчилал хэмжил зүйн газар /цаашид "СХЗГ" гэх/,<br>БОНХАЖЯ |
| | | | Шинээр нэвтрүүлэх олон улсын стандартын тоо | 1 | | |
| 9.5 | ЗГҮАХХҮАТ-ний 60.1 дэх заалт | Уул уурхайн үйл ажиллагаанаас болж эвдрэлд орсон талбайд нөхөн сэргээлт хийлгүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | БОНХАЖЯ,<br>УУЯ |
| **Зорилт 10.Бодит салбарын хөгжлийг дэмжсэн шинжлэх ухаан, технологийн хөгжлийн бодлого баримтална.** | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 10.1 | ЗГҮАХХАХТ-ний 202.4 дэх заалт | Шинжлэх ухаан, технологийн эрх зүйн орчныг сайжруулах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам /цаашид “БСШУЯ” гэх/ |
| 10.2 | **ЗГҮАХХАХТ-ний 202.4 дэх заалт** | “Монгол Улсын шинжлэх ухаан, технологийг 2007-2020 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөө”-ний III үе шатыг хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | БСШУЯ |
| 10.3 | ЗГҮАХХАХТ-ний 283.3 дахь заалт | Монгол Улсын насанд хүрсэн иргэн, хуулийн этгээд, төрийн албан хаагч нарт цахим гарын үсэг олгох ажлыг үргэлжлүүлэх | Цахим гарын үсэг олгох ажлын явц, хувиар | 50.0 | - | Мэдээллийн технологи, шуудан, харилцаа холбооны газар /цаашид “МТШХХГ” гэх/ |
| **ГУРАВ.БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖИЛ, БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО** | | | | | | |
| **Зорилт 11.Хүн амын нутагшилт, суурьшил, бүс нутгийн зохистой тогтолцоонд тулгуурлан хот, суурин хөгжүүлж, газар ашиглалтыг сайжруулна.** | | | | | | |
| 11.1 | ЗГҮАХХАХТ-ний 115.5 дахь заалт | Төв аймгийн Хөшигийн хөндийн шинэ хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө болон эхний ээлжийн барилгажилтын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах | Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тоо | 1 | 0.3 Улсын төсөв | Барилга, хот байгуулалтын яам / цаашид “БХБЯ/, ЗТЯ |
| | | | Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тоо | 1 | | |
| 11.2 | ЗГҮАХХАХТ-ний 130.2 дахь заалт | Монгол Улсын иргэнд өмчлүүлэх боломжтой газарт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, байр зүйн зураглал, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулах ажлыг үргэлжлүүлэх | Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх талбайн хэмжээ, мянган га | 48.5 | 2.4 Улсын төсөв | БХБЯ |
| 11.3 | ҮХЦБ-ын 5.3.5.3 дахь зорилт, ЗГҮАХХАХТ-ний 3.7 дахь заалт | Бага, дунд орлоготой иргэдэд зориулсан түрээсийн орон сууцыг барьж ашиглалтад оруулах | Ашиглалтад орох орон сууцны тоо | 1300 | 90.0 ТХХТ | БХБЯ, АҮЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 11.4 | ҮХЦБ-ын 5.3.5.3 дахь зорилт, ШББДХЗХХҮАТ -ний 4.4.2.1. ЗГҮАХХАХТ-ний 127.2 дахь заалт | Аймаг, нийслэлийн ус хангамж, ариутгах татуургын барилга байгууламж, шугам сүлжээг үе шаттай шинэчлэх | Цэвэрлэх байгууламжийг шинэчлэх аймгийн тоо | 5 | 15.7 Хөгжлийн банк Гадаад эх үүсвэр | БХБЯ, АНЗДТГ |
| | | | Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээг шинэчлэх аймгийн тоо | 1 | | |
| 11.5 | ЗГҮАХХАХТ-ний 267.4 дэх заалт | Газар хөдлөлтийн эрсдэл бүхий хот, суурин газар, бүсүүдийн тулгуур төв болон зарим суурин газрын нутаг дэвсгэрийн хэмжээнд 1:10000-ны масштабтай газар хөдлөлтийн бичил мужлалын зураг зохиох ажлыг үе шаттай хэрэгжүүлж дуусгах | Бичил мужлалын зураг хийгдэж дуусах аймгийн тоо | 12 | 0.9 Улсын төсөв | БХБЯ, БСШУЯ, АЗДТГ |
| **Зорилт 12.Хөдөөгийн хөгжлийг дэмжиж, хүн амын амьдрах орчныг сайжруулна.** | | | | | | |
| 12.1 | Засгийн газрын 2013 оны 226 дугаар тогтоол | Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлыг эхлүүлэх | Байгуулах үйлдвэрлэл, технологийн паркийн тоо | 10 | 40.0 ТХХТ | АҮЯ, ХХААЯ |
| 12.2 | Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын 3.1.6 дахь заалт | Малчдыг нийгмийн даатгалд хамрагдах, малаа даатгуулах сонирхлын хөшүүргийг бий болгох | Нийгмийн даатгалд хамрагдах малчдын тооны өсөлт, хувиар | 10.0 | - | ХХААЯ, ХАХНХЯ, АНЗДТГ |
| | | | Индексжүүлсэн даатгалд хамрагдах малын тооны өсөлт, хувиар | 10.0 | - | |
| 12.3 | Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын 2.3.1 дэх заалт | Малчдыг орон нутагтаа тав тухтай ажиллаж, амьдрах нөхцөлөө бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж, ХАА-н биржийн арилжаан дахь оролцоог нэмэгдүүлэх | ХАА-н биржийн арилжаанд оролцох малчдын тооны өсөлт, хувиар | 15.0-аас доошгүй | - | ХХААЯ, “Хөдөө аж ахуйн бирж”ХК |
| 12.4 | ЗГҮАХХАХТ-ний 93 дахь заалт | Хүлэмжийн аж ахуйн тоо, хэмжээг нэмэгдүүлж, таримлын нэр төрлийг олшруулах | Шинээр байгуулах зун, өвлийн хүлэмжийн талбайн хэмжээ, мян.$м^2$ | 100 | - | ХХААЯ |
| | | | Нэмэгдүүлэх ургацын хэмжээ, тонн | 2000 | | |
| 12.5 | ЗГҮАХХАХТ-ний 141.4 дэх заалт | Харилцаа холбооны үндсэн сүлжээнд холбогдоогүй сумдыг шилэн кабелийн сүлжээнд холбох | Шилэн кабельд холбогдох сумын тоо | 2 | - | МТШХХГ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 12.6 | ЗГҮАХХҮАТ-ний 34.2, 146.5 дахь заалт | Монгол мал хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийг хөгжүүлэх хүрээнд хоршоодыг дэмжиж бүх сумдад мал аж ахуйн гаралтай бараа, түүхий эд бэлтгэх үндэсний сүлжээ бий болгох | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | ХХААЯ |
| 12.7 | ЗГҮАХХҮАТ-ний 72.6, 240.2 дахь заалт | Бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээр сэргээх, малын тэжээл бэлтгэх иргэдийн санаачилгыг дэмжих төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | ХХААЯ |
| 12.8 | ҮХЦБ-ын 5.3.2 дахь заалт ЗГҮАХХҮАТ-ний 100 дахь заалт | Эрчим хүч, авто бензин, дизелийн түлшний үнийг Монгол Улсын хэмжээнд ижил байх эрх зүйн орчныг бүрдүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | АҮЯ, ЭХЯ, УУЯ |
| **Зорилт 13.Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгож, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх бодлогыг хэрэгжүүлнэ.** | | | | | | |
| 13.1 | ЗГҮАХХҮАТ-ний 79.1 дэх заалт | Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох | Боловсруулах эрх зүйн баримт бичгийн төслийн тоо | 5-аас доошгүй | - | БОНХАЖЯ |
| 13.2 | ЗГҮАХХҮАТ-ний 229.1 дэх заалт | Хог хаягдлыг дахин боловсруулж, эрчим хүч, түүхий эд үйлдвэрлэх эко цогцолбор байгуулах | Байгууламжийн тоо | 1 | 300.0 ТХХТ | БОНХАЖЯ, АҮЯ |
| 13.3 | ЗГҮАХХҮАТ-ний 230.2 дахь заалт | Бороо, цасны усыг хуримтлуулах хөв цөөрөм байгуулах, булаг шандны эхийг хашиж хамгаалах | Байгуулах хөв цөөрмийн тоо | 3 | 0.45 Орон нутгийн төсөв | БОНХАЖЯ, ХХААЯ, АНЗДТГ |
| | | | Хамгаалалт хийх булаг шандны тоо | 120-иос доошгүй | 0.24 Орон нутгийн төсөв | БОНХАЖЯ, АНЗДТГ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 13.4 | ЗГҮАХХҮАТ-ний 232.3 дахь заалт | Улсын тусгай хамгаалалттай болон орон нутгийн тусгай хэрэгцээт газрын ашиглалтыг зохистой түвшинд байлгах зорилгоор эрх зүйн орчныг сайжруулах | Тусгай хамгаалалтад авах талбайн хэмжээ, га | 600.0 | 0.01<br>Улсын төсөв | БОНХАЖЯ |
| 13.5 | “Ус” үндэсний хөтөлбөрийн 3.3.2 дахь заалт | Туул усан цогцолбор, Орхоны шинэ нуур, Шүрэнгийн УЦС-ын ажлын зураг төслийг боловсруулах | Зураг төслийн тоо | 3 | 9.4 сая ам.доллар<br>Гадаад эх үүсвэр | БОНХАЖЯ,<br>ЭХЯ |
| 13.6 | “Ус” үндэсний хөтөлбөрийн 3.3.3, 3.3.4, 3.3.5 дахь заалт | Гидрогеологийн зураглал, ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийн хайгуул, судалгаа хийх | Хайгуул судалгааны ажлын тоо | 3 | 0.6<br>Улсын төсөв | БОНХАЖЯ |
| 13.7 | ЗГҮАХХҮАТ-ний 34 дэх заалт | Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах цогц, үр дүнтэй арга хэмжээ авах | Нарийн ширхэгт тоосонцор (PM 2.5), хүхэрлэг хий (SO2)-н агууламжийн бууралт, хувиар | 20-иос доошгүй | - | БОНХАЖЯ,<br>НЗДТГ |
| 13.8 | ЗГҮАХХҮАТ-ний 79.3, 79.5 дахь заалт | Аялал жуулчлалын салбарын дэд бүтцийг сайжруулах, бүтээгдэхүүн үйлчилгээний хөгжлийг дэмжих | Жуулчдын тоон өсөлт, хувиар | 20-иос доошгүй | - | БОНХАЖЯ |
| Зорилт 1**4.Гамшгаас хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгож, мэргэжлийн байгууллагын бие бүрэлдэхүүн, аврагчийн бие** бялдрын тэсвэр хатуужил, сэтгэл зүйн бэлтгэлийг төлөвшүүлнэ. | | | | | | |
| 14.1 | Гамшгаас хамгаалах чадавхыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр /цаашид “ГХЧБҮХ” гэх/-ийн 3.3.1, 3.3.2, 3.3.4 дэх зорилт | Гамшгаас хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох | Боловсруулах хуулийн төслийн тоо | 1 | - | Шадар сайдын ажлын алба,<br>Хууль зүйн яам<br>/цаашид “ХЗЯ” гэх/ |
| | | | Боловсронгуй болгох хуулийн төслийн тоо | 1 | | |
| 14.2 | ГХЧБҮХ-ийн 3.5.4 дэх зорилт, ЗГҮАХХАХТ-ний 264.8 дахь заалт | Гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн хор уршгийг арилгах, аврах, гал унтраах ангийн чадавхыг сайжруулах | Ашиглалтад орох аврах, гал унтраах ангийн тоо | 5 | 2.3<br>Улсын төсөв | Онцгой байдлын ерөнхий газар<br>/цаашид “ОБЕГ” гэх/ |
| 14.3 | ГХЧБҮХ-ийн 3.5.4 дэх зорилт, ЗГҮАХХАХТ-ний 264.8 дахь заалт | Онцгой байдлын албаны гал унтраах техник, тоног төхөөрөмжийг сайжруулах төсөл хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | 11.0<br>Гадаад эх үүсвэр | ОБЕГ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 14.4 | Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогын 2.2 дахь заалт, ЗГҮАХХАХТ-ний 264.7 дахь заалт | Мэргэжлийн байгууллагын бие бүрэлдэхүүн, аврагчдын дайчилгааны дараах бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлийг төлөвшүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | ОБЕГ<br>Эрүүл мэнд, спортын яам /цаашид "ЭМСЯ" гэх/ |
| ДӨРӨВ.ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО | | | | | | |
| **Зорилт 15.Хүүхэд, сурагч, оюутан нэг бүрийг хөгжүүлж, багш нарын ур чадварыг дээшлүүлнэ.** | | | | | | |
| 15.1 | ЗГҮАХХАХТ-ний 186.1 дэх заалт | Ерөнхий боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах | Шинээр нэмэгдэх суудлын тоо | 10,000-аас доошгүй | 25.0<br>Улсын төсөв | БСШУЯ |
| 15.2 | ЗГҮАХХАХТ-ний 187.9 дэх заалт | Ерөнхий боловсролын сургуулийн I-V болон X-XII ангийн сурах бичгийн агуулга, стандартыг шинэчилж, нөхөн хангалт хийх | I-V, X-XII ангийн сурах бичгийн нэр төрлийн тоо | 49 | 2.0<br>Улсын төсөв | БСШУЯ |
| 15.3 | ЗГҮАХХАХТ -ний 201.1, 201.2, 201.3 дахь заалт | Багш, инженерийн чиглэлийн мэргэжлээр амжилттай суралцаж байгаа оюутны сургалтын төлбөрт хөнгөлөлт үзүүлэх | Хөнгөлөлт үзүүлэх оюутны тоо | 3000 хүртэл | 3.0<br>Улсын төсөв | БСШУЯ |
| 15.4 | ЗГҮАХХАХТ -ний 204.2 дахь заалт | Инженер, технологийн дээд боловсрол төслийн хүрээнд судлаач, оюутныг сургалтад хамруулах | Зэргийн бус хөтөлбөрт шинээр элсүүлэх оюутны тоо | 67 | 9.3<br>Гадаад эх үүсвэр | БСШУЯ |
| | | | Магистр, докторын хөтөлбөрт шинээр элсүүлэх оюутны тоо | 40 | | |
| | | | Коосэн хөтөлбөрт шинээр элсүүлэх оюутны тоо | 40 | | |
| 15.5 | ЗГҮАХХАХТ -ний 200 дахь заалт | Багануур дахь их сургуулиудын хотхоны дэд бүтэц, барилга, байгууламжийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх | Дэд бүтцийн барилгын ажлын явц, хувиар | 5.0 | 5.0<br>ТХХТ | БСШУЯ |
| 15.6 | ЗГҮАХХАХТ -ний 201.1, 201.2, 201.3 дахь заалт | "Дээд боловсролын шинэчлэл" төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | 17.0<br>Гадаад эх үүсвэр | БСШУЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 15.7 | ЗГҮАХХАХТ -ний 204.1, 204.2 дахь заалт | Дэлхийн шилдэг сургуулиудад бакалавр, магистр, докторын хөтөлбөрт оюутан суралцуулж, өрсөлдөх чадвартай монгол хүнийг хөгжүүлэх | Суралцуулах оюутны тоо | 120 | 11.5 Улсын төсөв | БСШУЯ |
| 15.8 | ЗГҮАХХАХТ-ний 205.3 дахь заалт | Тусгай хэрэгцээт боловсролын сургалтын орчинд үнэлгээ хийж, сургалтын хөтөлбөр, сурах бичгийг боловсронгуй болгох | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | 0.5 Гадаад эх үүсвэр | БСШУЯ |
| 15.9 | ЗГҮАХХАХТ-ний 91 дэх заалт | Монгол-Энэтхэгийн хамтарсан мэдээллийн технологийн боловсрол, аутсорсингийн төвийн барилгын ажлыг эхлүүлэх | Барилгын бэлтгэл ажлын явц, хувиар | 100.0 | 12.8 Гадаад эх үүсвэр | БСШУЯ |
| 15.10 | ЗГҮАХХАХТ-ний 187.8, 187.9 дэх заалт | Хүүхдийн хөгжил, төлөвшлийг хангах зорилгоор “Зөв Монгол хүүхэд” үндэсний хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх | Лабораторийн тоног төхөөрөмжөөр хангагдах сургуулийн тоо | 125 | 1.0 Улсын төсөв 4.0 Гадаад эх үүсвэр | БСШУЯ |
| 15.11 | ЗГҮАХХАХТ-ний 193.1 дэх заалт | Боловсролын байгууллагын мэдээллийн нэгдсэн сан бүхий “Боловсролын салбарын мэдээллийн систем”-ийг боловсруулж, нэвтрүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | 1.5 Улсын төсөв, Гадаад эх үүсвэр | БСШУЯ |
| 15.12 | ЗГҮАХХАХТ-ний 300 дахь заалт | Төрөөс залуучуудын талаар баримтлах бодлогыг шинэчилж, залуучуудын асуудлыг гэр бүл, хүүхэд, эмэгтэйчүүд, хүн амын хөгжлийн бодлоготой уялдуулах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | ХАХНХЯ |
| Зорилт 1**6.Эх орондоо эрүүл мэндийн оношилгоо, эмчилгээг чанарын өндөр түвшинд хийх боломжийг бүрдүүлнэ.** | | | | | | |
| 16.1 | ЗГҮАХХАХТ-ний 165.2, 168.1, 174.1 дэх заалт | Эрүүл мэндийн үйлчилгээний чанар, стандартыг дээшлүүлж, ажиллагчдын ёс зүй, хариуцлагыг сайжруулах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | ЭМСЯ |
| 16.2 | ЗГҮАХХАХТ-ний 169.1 дэх заалт | Эмчилгээ, оношилгооны тоног төхөөрөмжийг сайжруулж, шаардлагатай эмнэлгийн барилгуудад их засвар хийх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | 14.0 Улсын төсөв | ЭМСЯ, СЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 16.3 | ЗГҮАХХАХТ-ний 165.1 дэх заалт | Оношилгоо, эмчилгээний стандартыг үе шаттайгаар шинэчлэн боловсруулж, мөрдүүлэх | Шинээр боловсруулах стандарт, зааврын төслийн тоо | 10 | - | ЭМСЯ |
| 16.4 | ЗГҮАХХАХТ-ний 176.1 дэх заалт | Алслагдсан сумдыг телемедицины үндэсний сүлжээний дэд бүтцэд холбох | Телемедицины сүлжээнд холбогдох сумын тоо | 8 | 0.5 Улсын төсөв | ЭМСЯ |
| 16.5 | ЗГҮАХХАХТ-ний 165.1 дэх заалт | Сонгинохайрхан дүүрэгт загвар нэгдсэн эмнэлэг барих ажлыг эхлүүлэх | Барилга угсралтын ажлын явц, хувиар | 10.0 | 6.6 сая ам.доллар Гадаад эх үүсвэр | ЭМСЯ |
| 16.6 | Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал 3.4.1.3, Хүнсний тухай хууль 9.1.1, 9.1.2 дахь заалт | Хүн амын хоол тэжээл, өрхийн хүнсний хэрэглээ, хүн амын эрүүл мэндийн эрсдэлийг үнэлэх үндэсний судалгааг зохион явуулах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | 0.3 Гадаад эх үүсвэр | ЭМСЯ |
| 16.7 | ҮХЦБ-ын 4.5.2 дахь зорилт, ЗГҮАХХАХТ-ний 167.5 дахь заалт | Э***мийн чанар, аюулгүй байдлын цахим мэдээллийн тогтолцооны системийг нэвтрүүлэх*** | Нэвтрүүлэх программ хангамжийн тоо | 2 | 0.5 Улсын төсөв | ЭМСЯ |
| 16.8 | ЗГҮАХХАХТ-ний 184.1 дэх заалт | **Даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, өвчнийг эрт илрүүлэх үзлэг,** оношилгоонд тогтмол хугацаанд хамруулах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | ЭМСЯ, ХАХНХЯ |
| 16.9 | ҮХЦБ-ын 4.5.1 дэх зорилт | **Эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах тухай хууль гаргаж, төр, гэр бүл, иргэн бүрийн үүрэг хариуцлагыг сайжруулах** | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | ЭМСЯ, ХАХНХЯ |
| Зорилт 1**7.Соёл,** биеийн тамир, спортыг тогтвортой хөгжүүлж, биеийн тамирыг хүний өдөр тутмын хэрэглээ болгох бодлого баримтална. | | | | | | |
| 17.1 | “Биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах бодлого”-ын 3.2 дахь заалт, ЗГҮАХХАХТ-ний 214 дэх заалт | Бүх нийтийг хамарсан биеийн тамир, спортын арга хэмжээ, тэмцээн, наадмын зохион байгуулалтын тогтолцоог боловсронгуй болгох | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | ЭМСЯ |
| 17.2 | ЗГҮАХХАХТ-ний 138.1, 140.1 дэх заалт | Хүүхэд, залуучуудад зориулсан спорт үйлчилгээний цогцолбор, усан бассейн байгуулах | Шинээр ашиглалтад орох спорт цогцолборын суудлын тоо | 5000 | 31.5 Улсын төсөв | ЭМСЯ |
| | | | Шинээр ашиглалтад орох усан бассейны тоо | 1 | 2.0 Улсын төсөв | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 17.3 | “Биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах бодлого”-ын 2.2.2 дахь заалт | Төр, төрийн бус байгуулага, аж ахуйн нэгж, байгууллагын түншлэлийг хөгжүүлэх замаар биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн бүх шатны магадлан итгэмжлэлийг эхлүүлэх | Шинэчлэх журмын төслийн тоо | 1 | - | ЭМСЯ |
| | | | Магадлан итгэмжлэх ажлын явц, хувиар | 100.0 | | |
| 17.4 | “Төрөөс соёлын талаар баримтлах бодлого”-ын 4.3 дахь заалт | Соёлын биет бус өвийг хамгаалах үндэсний хөтөлбөр боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх | Шинээр боловсруулах хөтөлбөрийн тоо | 1 | - | БСШУЯ |
| Зорилт **18.Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх ажлыг эрчимжүүлж,** ажлын байрыг нэмэгдүүлнэ. | | | | | | |
| 18.1 | ҮХЦБ-ын 4.8.2.1 дэх зорилт | Ажил олгогчидтой хамтран хөдөлмөрийн зах зээлд шаардлагатай мэргэжлийн хэрэгцээг тодорхойлох, тэдгээрт нийцүүлэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх, мэргэжлийн ур чадвар олгох үйлдвэрлэл дээрх сургалтыг өргөжүүлэх | Боловсронгуй болгох хуулийн төслийн тоо | 1 | - | ХЯ |
| | | | Үйлдвэрлэл дээрх болон хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамрагдах иргэдийн тоо | 2500 | | |
| 18.2 | ҮХЦБ-ын 4.8.3 дахь зорилт | Залуучууд, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, байнгын ажлын байраар хангахад чиглэсэн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | 6.0 Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан/ цаашид “ХЭДС” гэх/ | ХЯ |
| 18.3 | “Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний тухай” олон улсын хөдөлмөрийн байгууллагын 88, 181 дүгээр Конвенци | Ажилд зуучлах, зөвлөх бэлтгэх, мэргэшүүлэх, мэргэжлийн чиг баримжаа олгох тогтолцоог сайжруулах | Ажлын байранд зуучлагдсан иргэдээс байнгын ажлын байртай болох иргэдийн хувь | 60.0 – аас доошгүй | 1.0 ХЭДС | ХЯ |
| | | | Боловсронгуй болгох журмын төслийн тоо | 1 | | |
| | | | Сургалтын хөтөлбөрийн тоо | 3 | | |
| 18.4 | ЗГҮАХХАХТ-ний 20.1 дэх заалт | Хөдөлмөрийн хөлсийг цагаар олгох зохистой хэлбэрийг судалж, цалингийн хэмжээг инфляцийн түвшин, хөдөлмөрийн бүтээмжтэй уялдуулан индексжүүлж нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх | **Боловсруулах хуулийн төслийн тоо** | 1 | - | ХЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 18.5 | ЗГҮАХХАХТ-ний 20.1 дэх заалт | Цалин, тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх асуудлыг улсын төсвийн боломжтой уялдуулан судалж, шийдвэрлэх | Үйл ажиллагааны хэрэгжилтээр, хувиар | 100.0 | - | ХЯ, ХАХНХЯ, СЯ |
| 18.6 | Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талтын 2015-2016 оны хэлэлцээрийн 3.2 дахь заалт | Хувь хүний албан татвар тооцох орлогоос хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү хэмжээгээр хөнгөлөлт үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх | Боловсруулах хуулийн төслийн тоо | 1 | - | ХЯ, СЯ |
| 18.7 | ҮХЦБ-ын 4.8.2 дахь зорилт | Гадаадаас ажиллах хүч авах тогтолцоог боловсронгуй болгож, ажиллах хүчинд тавигдах шаардлагыг сайжруулж, зуучлалын үйл ажиллагааг эрхлэх байгууллагын үйлчилгээний чанарыг сайжруулах | Боловсронгуй болгох хуулийн төслийн тоо | 1 | - | ХЯ, СЯ, ХЗЯ |
| 18.8 | Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.21 дэх заалт | Мэргэшлийн түвшний үндэсний тогтолцоог бүрдүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах | Боловсруулах бодлогын баримт бичгийн төслийн тоо | 1 | - | ХЯ, БСШУЯ |
| | | | Ур чадварын түвшинг тодорхойлох мэргэжлийн тоо | 10- аас доошгүй | | |
| 18.9 | Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1, 8.4.3 дахь заалт | Мэргэжлийн боловсрол, сургалтын тэргүүлэх чиглэлийг тогтоох замаар төрөлжүүлэх бодлогыг боловсруулах | Төрөлжүүлэх мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын тоо | 37 | - | ХЯ |
| **Зорилт 19.Нийгмийн даатгал, нийгмийн хамгааллын салбарт хийх шинэчлэлийн бодлогыг үргэлжлүүлнэ.** | | | | | | |
| 19.1 | ЗГҮАХХАХТ-ний 161.3 дахь заалт | Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сүлжээнд сумдын мэдээллийг холбох үйл ажиллагааг үе шаттай хэрэгжүүлэх | Нэгдсэн сүлжээнд холбох ажлын явц, хувиар | 80.0 | - | ХАХНХЯ |
| 19.2 | ҮХЦБ-ын 4.3.1 дэх зорилт | "Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн шаталсан хөтөлбөр"-ийг боловсруулж, хэрэгжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | ХАХНХЯ, Хүүхдийн төлөө үндэсний газар /цаашид "ХТҮГ" гэх/ |
| 19.3 | Засгийн газрын 2011 оны 347 дугаар тогтоолоор батлагдсан Хүүхэд хамгааллыг бэхжүүлэх стратеги (2012-2015) төлөвлөгөөний 6 дахь зорилт | Хүүхэд хамгааллын тусламжийн цогц, шуурхай үйлчилгээг хөгжүүлэх ажлын хүрээнд хүүхдийн тусламжийн утсанд ирсэн дуудлагаас шууд яаралтай тусламж үзүүлэх, хариу арга хэмжээ авах | Дуудлагын шийдвэрлэлтийн явц, хувиар | 100.0 | 0.2 Улсын төсөв | ХАХНХЯ, ХТҮГ |
| | | | Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлын явц, хувиар | 100.0 | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 19.4 | ЗГҮАХХАХТ-ний 157.1 дэх заалт | **Өндөр настны асрамжийн төв байгуулах хувийн хэвшлийн санаачилгыг дэмжих** | **Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар** | 100.0 | - | **ХАХНХЯ** |
| 19.5 | **ЗГҮАХХАХТ-ний 155.1 дэх заалт** | **Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээнд ахмадуудыг зуучлан хамруулах, богиносгосон цагаар ажиллах боломжийг бүрдүүлэх** | **Бий болох үндэсний сүлжээний тоо** | 1 | - | **ХАХНХЯ, ХЯ** |
| 19.6 | **ЗГҮАХХАХТ-ний 161.4 дэх заалт** | Өрхийн мэдээллийн нэгдсэн санд үндэслэн өрхийн амьжиргааны түвшнээр ангилсан шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлэх | Нэвтрүүлэх шинэ төрлийн үйлчилгээний тоо | 2-3 | - | ХАХНХЯ |
| 19.7 | ҮХЦБ-ын 4.3.1, 4.3.3 дахь зорилт | “Олон хүүхэд төрүүлсэн эх, олон хүүхэдтэй гэр бүлийг дэмжих” хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх | Шинээр боловсруулах хөтөлбөрийн тоо | 1 | - | ХАХНХЯ |
| 19.8 | ҮХЦБ-ын 4.3.2 дахь зорилт | Ахмадуудаа халамжлах, ач санах хууль боловсруулах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | ХАХНХЯ |
| 19.9 | ҮХЦБ-ын 4.8 дахь зорилт | Нөхцөлт мөнгөн шилжүүлгийн зарчмыг нийгмийн бодлого, тэтгэвэр тэтгэмж, халамжийн бодлогод тусган хэрэгжүүлэх талаар иж бүрэн арга хэмжээ авах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | ХАХНХЯ |
| ТАВ.ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ, ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ САЛБАРЫН БОДЛОГО | | | | | | |
| Зорилт 2**0.Хууль тогтоомж, эрх зүйн шинэчлэлийн бодлогыг дэмжих ажлыг үргэлжлүүлнэ.** | | | | | | |
| 20.1 | ЗГҮАХХАХТ-ний, 30.6. 30.7, 34.9 дэх заалт, ЗГҮАХХАХТ-ний 196 дахь заалт | Ял шийтгүүлсэн этгээдийг ажлын байраар хангах- мэргэжлийн сургалтад хамруулах, улмаар суллаг-<br>дан гарахад ажил хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх | Ашиглалтад оруулах үйлдвэрийн төрөл | 4 | 0.8<br>Улсын төсөв | ХЗЯ,<br>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар /цаашид “ШШГЕГ” гэх/ |
| | | | Ажлын байраар хангах хувь | 60 | | |
| | | | Нийт хорих ял эдлэгсдэд тусгай дунд боловсрол эзэмшүүлэх хувь | 50 | | |
| 20.2 | ЗГҮАХХАХТ-ний 259.6 дахь заалт | Гадаад орнуудын архивт хадгалагдаж байгаа Монгол Улсын түүх соёлтой холбогдох баримтыг илрүүлэх, тэдгээрийг хуулбарлах, худалдан авах замаар сан хөмрөгийг баяжуулах | Сан хөмрөгийг баяжуулах ажлын явц, хувиар | 20 | - | ХЗЯ,<br>Архивийн ерөнхий газар |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 20.3 | ҮХЦБ-ын 7.2.5 дахь зорилт | Аймгуудын эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын баримтыг цахимжуулах | Хамрагдах аймгийн тоо | | 15.0<br>Гадаад эх үүсвэр | ХЗЯ,<br>УБЕГ |
| 20.4 | ҮХЦБ-ын 7.2 дахь зорилт, ЗГҮАХХАХТ-ний 17.1 дэх заалт | Төрөөс худалдан авах ажиллагааны талаар баримтлах бодлогын цогц баримт бичиг боловсруулах, эрх зүйн орчныг сайжруулах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | СЯ,<br>Худалдан авах ажиллагааны газар |
| 20.5 | ЗГҮАХХАХТ-ний 297.1 дэх заалт | Төрийн аудитын чанарыг сайжруулж, үйлчилгээг ил тод, хүртээмжтэй болгох | Цахим мэдээллийн сан бүрдүүлэх ажлын явц, хувиар | 100.0 | 1.0<br>Улсын төсөв | Үндэсний аудитын газар |
| 20.6 | ҮХЦБ-ын 5.3.4 дэх зорилт, ЗГҮАХХАХТ-ний 283 дахь заалт | Төрийн үйлчилгээний ил тод, шуурхай байдлыг хангах зорилгоор нээлттэй ухаалаг төрийн удирдлагын системийг нэвтрүүлэх | Удирдлагын систем суурилагдах дүүргийн тоо | 6 | 1.2<br>Гадаад эх үүсвэр | МТШХХГ |
| 20.7 | ҮХЦБ-ын 7.3. дахь заалт, ЗГҮАХХАХТ-ний 302.1, 302.2 дахь заалт | Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны удирдлагын байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхой болгож, давхардлыг арилгах, бодлогын нэгдмэл чанарыг хангах чиглэлээр холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | Засгийн газрын Хэрэг эрхлэх газар,<br>ХЗЯ |
| 20.8 | ЗГҮАХХАХТ-ний 17 дахь заалт | Төрийн захиалгаар гэрээний дагуу бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн аж ахуйн нэгжийн төлбөрийг тухайн санхүүгийн жилд багтаан гүйцэтгэж байх эрх зүйн орчныг сайжруулах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | СЯ |
| 20.9 | ЗГҮАХХАХТ-ний 17, 27.1 дахь заалт | Төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөлттэй уялдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг боловсронгуй болгох | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | СЯ |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 20.10 | ЗГҮАХХАХТ-ний 15.2, 169.2, 264.5 дахь заалт | Архивын шинэ барилга, Төрийн албан хаагчийн нэгдсэн эмнэлэгийн тоног төхөөрөмжийн зардал, түүнчлэн шинээр баригдаж ~~буй~~ байгаа хорих ангийн барилгын санхүүжилтийг шийдвэрлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | ХЗЯ, ШШГЕГ |
| 20.11 | ЗГҮАХХАХТ-ний 15.2, 306.1 дэх заалт | Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт баригдаж ~~буй~~ байгаа шүүх, прокурорын барилгын санхүүжилтийг шийдвэрлэх 2016 оны төсөвт тусгах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | ХЗЯ |
| 20.12 | ЗГҮАХХАХТ-ний 291.2, 310.1 дэх заалт | Гэрч, хохирогчийг хамгаалах, Тахарын албыг бэхжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалт" гэсэн заалтыг 2016-2018 оны төсвүүдэд тусгайлан тусгах | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | - | ХЗЯ |
| **Зорилт 21.Энхийг эрхэмлэсэн, нээлттэй, бие даасан, олон тулгуурт, идэвхитэй гадаад бодлого явуулна.** | | | | | | |
| 21.1 | ҮХЦБ-ын 7.5.1 дэх зорилт, ЗГҮАХХАХТ-ний 253 дахь заалт | ОХУ, БНХАУ-тай тэнцвэртэй харилцах бодлого баримталж, стратегийн түншлэлийн харилцааг бататган бэхжүүлэх | Дээд түвшинд хийгдэх уулзалтын тоо | 2 | - | ГХЯ |
| 21.2 | ҮХЦБ-ын 7.5.1 дэх зорилт, ЗГҮАХХАХТ-ний 253.10 дахь заалт | Ази, Номхон далайн эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага (АПЕК)-д элсэх чиглэлээр үргэлжлүүлэн ажиллах | Дэмжихээ илэрхийлэх улсын тоо | 2-оос доошгүй | - | ГХЯ |
| 21.3 | ҮХЦБ-ын 7.5.1 дэх зорилт, ЗГҮАХХАХТ-ний 253.10 дахь заалт | Зүүн Азийн дээд түвшний уулзалтын гишүүн улс болох чиглэлээр ажиллах | Дэмжихээ илэрхийлэх улсын тоо | 2-оос доошгүй | - | ГХЯ |
| 21.4 | ҮХЦБ-ын 7.5.1 дэх зорилт, ЗГҮАХХАХТ-ний 253 дахь заалт | Ази, Европын дээд түвшний 11 дүгээр уулзалтыг 2016 онд Улаанбаатар хотод зохион байгуулах | Дэмжин оролцох улсын тоо | 51 | 50.0 Улсын төсөв | ГХЯ |
| 21.5 | ҮХЦБ-ын 7.5.1 дэх зорилт, ЗГҮАХХАХТ-ний 259 дэх заалт | "Монгол Улсыг гадаадад сурталчлах хөтөлбөр"-ийг боловсруулж, хэрэгжүүлэх | Хэрэгжих хөтөлбөрийн тоо | 1 | - | ГХЯ, БОНХАЖЯ |
| 21.6 | ҮХЦБ-ын 7.5.3 дахь зорилт, ЗГҮАХХАХТ-ний 258 дахь заалт | Консулын үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх, цахим виз олгох ажлыг эхлүүлэх | Үйл ажиллагаа эхлүүлэх дипломат төлөөлөгчийн газрын тоо | 4 | 0.5 Улсын төсөв | ГХЯ |

| Зорилт 2**2.Батлан хамгаалахын чадавхийг нэмэгдүүлж, улс орны бүтээн байгуулалтад оролцох боломжийг дээшлүүлнэ.** | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 22.1 | ЗГҮАХХАХТ-ний 248, 250.2, 250.3 дахь заалт | Батлан хамгаалах, энхийг сахиулах үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар | 100.0 | 6.5 Улсын төсөв | Батлан хамгаалах яам / цаашид "БХЯ" гэх |
| 22.2 | ЗГҮАХХАХТ-ний 251.3 дахь заалт | "Цэргийн авто болон тусгай зориулалтын техникийн парк шинэчлэл" төслийг хэрэгжүүлэх хүрээнд зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний улс орны бүтээн байгуулалтад оролцох чадавхийг дээшлүүлэх | Авто техникийн бэлэн байдлын түвшин дээшлэх хувь | 100.0 | 1.2 Улсын төсөв | БХЯ |
| 22.3 | ЗГҮАХХАХТ-ний 247 дахь заалт | Монгол-Оросын хилийн дэглэмийн гэрээ, улсын хилийг хамтран шалгасан протоколын дагуу Монгол-Оросын хилийн багана, тэмдгийг засварлах | Засварлах хилийн тэмдгийн тоо | 643-аас доошгүй | - | ХЗЯ |

---oOo---

# МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2016 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД УЧИРЧ БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛҮҮД

Манай улсад сүүлийн жилүүдэд төлбөрийн тэнцлийн хүндрэлээс шалтгаалан эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдал үүсээд байгаа билээ. Өнгөрсөн 2014 онд гадаадын шууд хөрөнгө оруулалт 2011 онтой харьцуулахад 8,5 дахин буурч, дотоодын нийт бүтээгдэхүүний 5 хувьтай тэнцэх хэмжээнд хүрсэн нь 2009 оны санхүү, эдийн засгийн хямралын үед байсан түвшнээс ч бага болсон байна. Түүнчлэн 2012 оноос эхлэн гадаад худалдааны нөхцөл муудсанаар Монгол Улсын экспорт 2012 онд өмнөх оны түвшнээс 432 сая ам.доллар буюу 9 хувиар, 2013 онд өмнөх түвшнээс 115 сая ам.доллар буюу 3 хувиар тус тус буурав. Энэ нь Монгол Улсын гадаад цэвэр актив 2013-2014 онд ДНБ-ий 33.7 хувьтай тэнцэх хэмжээгээр огцом буурахад нөлөөллөө.

Монгол Улсын эдийн засагт 2012 оны сүүлийн хагасаас үүссэн төлбөрийн тэнцлийн хүндрэл нь 2013 онд хямралын шинжтэй болж, түүний сөрөг нөлөөлөл 2014 оны туршид үргэлжилсэн. Монгол Улсад орж ирэх гадаад валютын урсгал сүүлийн 2 жилийн туршид огцом буурсан нь мөнгөний нийлүүлэлт, банкны салбарын зээлийн өсөлтийг сулруулах, төсвийн орлого тасрах, бодит салбар, хувийн хэвшлийн идэвхжлийг удаашруулах, ханшийн нөлөөгөөр инфляци нэмэгдэх, валютын зээлийн эрсдэлийг өсгөх зэрэг сөрөг үр дагавартай байв.

Эдийн засагт үлэмж нөлөө бүхий томоохон төслүүд зогсонги байдалд орсон хэвээр, гадаад зээлийн боломж нэмэгдэхгүй бол 2015, 2016 онуудад мөнгөний нийлүүлэлт буурч, зээл тасалдах, төлбөрийн нийт тэнцлийн алдагдал ихээхэн нэмэгдэж, улмаар нийт эдийн засаг хумигдах эрсдэл өндөр байна. Төлбөрийн тэнцэл үргэлжлэн муудвал эдийн засгийн өсөлт улам саарч, бизнесийн идэвхжил удаашран хүндрэл үүсэх магадлалтай. Ийм орчинд валютын орох урсгалыг нэмэгдүүлж, макро бодлогын өөрчлөлтийг хийхгүй бол эдийн засгийг тогтворжуулах, дэмжих боломж бүрдэхгүй. Улмаар эдийн засгийн өсөлт огцом саарч, ажилгүйдлийг нэмэгдүүлэх сөрөг нөлөөлөл үүсч болзошгүй байна. Эдийн засгийг хумих, агшаах нь хувийн хэвшилд илүү их ачаалал дарамт үүсгэх, дотоод актив, иргэдийн хөрөнгө, хуримтлалыг үнэгүйдүүлэх, ажилгүйдэл эрс нэмэгдэх, эдийн засаг, нийгмийн тогтворгүй байдлыг бий болгох зэрэг сөрөг үр дагавартай.

Дээрх нөхцөл байдлаас үүдэн дэд бүтэц, бодит салбаруудын хэмжээнд хөрөнгө оруулалт буурснаар бүтээн байгуулалтын томоохон ажлууд хийгдэхгүй байх, хугацаа хойшлох зэрэг болзошгүй эрсдэл бий.

Эрчим хүчний салбарт баруун бүсийн цахилгаан станц, Дорнодын 100МВт чадалтай ДЦС-ыг барих ажлыг 2015-2016 онд эхлүүлээгүй нөхцөлд баруун аймгуудын эрчим хүчний хангамж доголдох, зүүн бүсийн уул уурхайн олборлолт, боловсруулах үйлдвэрийн хөгжил импортын эрчим хүчнээс хараат байх байдал нэмэгдэх зэрэг эрсдэл үүсэхээр байна. Төвийн бүсийн Дулааны цахилгаан станцуудын суурилагдсан чадал нь 864.3 МВт, өвлийн оргил ачаалал 2014 онд 969 МВт хүрч, 171МВт чадлын дутагдлыг ОХУ-аас импортолж хаасан байна. Уул уурхай, барилга болон эдийн засгийн бусад салбарын хөгжлийн эрчимжилт, хот суурин газрыг чиглэсэн хүн амын шилжилт, хөдөлгөөн нь эрчим хүчний төлөвлөгдөөгүй огцом өсөлтийг бий болгож, чадлын дутагдалд ороход сөргөөр нөлөөлөв. Оюу толгойн цахилгаан хангамжийг БНХАУ-ын импортоор хангаж байна. Цаашид ДЦС-5-ын цахилгаан, дулаан дамжуулах шугам, ус хангамж, төмөр зам зэрэг дэд бүтцийг байгуулах ажлыг 2016 оноос эхлүүлэн 2018 оонд дуусгасан байх шаардлагатай ба эдгээр ажлын хойшлолт нь ДЦС-5-ын барилга угсралтын ажлын хугацаанд нөлөөлж улмаар цахилгааны үнийг өсгөх, Монгол Улсын Засгийн газраас хүлээсэн үүргийн дагуу төлбөр төлөхөд хүргэх эрсдэлийг бий болгож болзошгүй байна. Улаанбаатар хотын Дулааны цахилгаан станц-5, Багануурын цахилгаан станцыг барих бүтээн байгуулалтын томоохон төслүүд хэрэгжиж, 2019 оноос тэдгээрийн эхний ээлж ашиглалтад орох үед Төвийн бүсийн дулааны цахилгаан станцуудын эрчим хүчний нүүсний хэрэгцээ одоогийнхоос даруй 2 дахин нэмэгдэж, 12 сая тоннд хүрэх төлөвтэй байна. Иймээс Багануурын нүүрсний уурхайн хүчин чадлыг 15 сая тонн, Шивээ-Овоогийн нүүрсний уурхайн хүчин чадлыг 10.0 сая тоннд хүргэх техникийн шинэчлэл, өргөтгөлийн ажлыг 2016 оноос эхлүүлж, 2018 онд эхний ээлжийг ашиглалтад оруулах чиглэлээр ажиллах шаардлагатай байна.

Хүнс, хөдөө аж ахуйн салбарын хүрээнд бэлчээрийн мал аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх улирлын хамаарал, анхан шатны боловсруулалт хийх, бүтээгдэхүүнийг хадгалах, тээвэрлэх зэрэг нийлүүлэлтийн нэгдсэн стандарт, орчин нөхцөл бүрдээгүй, цаашлаад түүхий эд бэлтгэл, тээвэр ложистикийн үндэсний хэмжээний нэгдсэн тогтолцоо байхгүй байгаа нь хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнэ, өртөг тогтвортой байхад сөргөөр нөлөөлж болзошгүй байна. ХАА-н салбарт байгаль, цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан ган, зуд тохиолдох зэрэг эрсдэлүүд тулгарч болзошгүй байна.

Эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх
Үндсэн чиглэлийн төслийн талаарх Засгийн
газрын танилцуулгаас хэсэгчлэн авч хавсаргав

## Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

| | 2011 | 2012 | 2013 | 2014* | 2015ХБГ | 2016** | 2017** | 2018** |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Бодит салбар** | | | | | | | | |
| ДНБ, оны үнээр/тэрбум.төг/ | 13173.8 | 16688.4 | 19118.0 | 21844.2 | 24027.1 | 27020.5 | 30427.5 | 34097.5 |
| ДНБ 2010 оны зэрэгцүүлэх үнээр, /тэрбум.төг/ | 11443.6 | 12853.4 | 14350.1 | 15472.9 | 16289.7 | 17108.5 | 17862.0 | 19068.2 |
| Нэг хүнд ногдох ДНБ /мян.тогрөг/ | 4728.0 | 5876.8 | 6594.7 | 7404.0 | 7931.3 | 8724.7 | 9613.7 | 10541.4 |
| Нэг хүнд ногдох ДНБ /ам.доллар/ | 3736.1 | 4323.6 | 4327.2 | 4072.3 | 4013.4 | 4413.6 | 4732.8 | 5147.4 |
| ДНБ-ий бодит өсөлт, хувиар | 17.3 | 12.3 | 11.6 | 7.8 | 5.3 | 5.0 | 4.4 | 6.8 |
| *Уул уурхайн салбарын бодит өсөлт* | 7.7 | 8.3 | 19.4 | 24.2 | 11.3 | -6.4 | -5.2 | 13.4 |
| *Уул уурхайн бус салбарын бодит өсэлт* | 19.9 | 13.3 | 9.8 | 3.6 | 3.4 | 8.8 | 7.1 | 5.1 |
| Хэрэглээний үнийн өсөлт, хувиар /оны эцэст/ | 10.2 | 14.0 | 12.5 | 11.0 | 9.0 | 7.0 | 7.0 | 7.0 |
| **Тосвиии тэнцэл /тэрбум тогрог/** | | | | | | | | |
| Нийт тэнцвэржүүлсэн орлого, тусламж | 4227.2 | 4881.2 | 5940.1 | 6223.4 | 6632.6 | 6642 | 6956.3 | 7316.4 |
| *ДНБ-д эзлэх хувь* | *32.1* | *29.2* | *31.1* | *28.5* | *27.6* | *24.6* | *22.9* | *21.5* |
| Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 4997.0 | 6017.8 | 6164.7 | 7031.4 | 7,837.4 | 7,723 | 7,869 | 7,998 |
| *ДНБ-д эзлэх хувь* | *37.9* | *36.1* | *32.2* | *32.2* | *32.6* | *28.6* | *25.9* | *23.5* |
| Тэнцвэржүүлсэн нийт тэнцэл | -769.9 | -1136.6 | -224.6 | -808.0 | -1204.8 | -1080.8 | -912.8 | -681.9 |
| *ДНБ-д эзлэх хувь* | *-5.8* | *-6.8* | *-1.2* | *-3.7* | *-5.0* | *-4.0* | *-3.0* | *-2.0* |
| **Гадаад тэнцэл /сая ам.доллар/** | | | | | | | | |
| Экспорт | 4817.5 | 4384.6 | 4269.1 | 5774.6 | 5163.8 | 5115.6 | 4978.5 | 5509.6 |
| Импорт | 6598.4 | 6738.4 | 6357.8 | 5236.6 | 4360.9 | 4962.4 | 5374.5 | 5768.7 |
| Гадаад худалдааны тэнцэл | -1746.5 | -2354.3 | -2088.8 | 537.9 | 802.9 | 153.2 | -396.0 | -259.1 |
| **Суурь үзүүлэлтүүд** | | | | | | | | |
| Хүн амын дуидаж тоо, мянган хүн | 2786.3 | 2839.7 | 2899.0 | 2995.9 | 3028.5 | 3094.2 | 3162.9 | 3232.0 |
| ДНБ, оны үнээр /сая ам.доллар/ | 10409.9 | 12277.8 | 12544.6 | 12014.7 | 12158.2 | 13668.9 | 14979.4 | 16649.9 |

*– урьдчилсан гүйцэтгэл   * *–төсөөлөл

Эх үүсвэр: Үндэсний Статистикийн Хороо, Сангийн яам

**© Энэхүү товхимолыг үнэгүй тарааж байгаа бөгөөд ашиг олох зорилгоор олшруулах, дахин хэвлэхийг хориглоно.**

*Боловсруулсан:* *Ж.Батсайхан*

*Хэвлэлийн эхийг бэлтгэсэн:* *Д.Цэцэгмаа*

*Д.Уранчимэг*

*ЭЗБХ–ны ажлын алба*
*Утас: 267451*
*Факс: 327016*